

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-42

- 1. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал** 11-12
 - 2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/** 13-16
 - 3. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 16-23
 - 4. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 23-30
 - 5. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 30-33
 - 6. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 33-39
 - 7. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 39-42
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
05 дугаар сарын 26-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 42 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Лодойсамбуу, Ц.Туваан;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Т.Доржханд, С.Зулпхар, Б.Найдалаа, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Э.Одбаяр, Б.Чойжилсүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлаас хойшлуулах тухай үг хэлж, хуралдаан даргалагч уг асуудлыг хойшлуулав./14:44/

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаар “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газраас 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, О.Алтангэрэл нар үг хэлэв.

Б.Жавхлан: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна.” гэж заасны “ ... 4 жил ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгчөөр ... зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр үг хэлэв.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 13
Бүгд: 19
31.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Л.Гантөмөр, Х.Тэмүүжин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 15
Бүгд: 19
21.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 15
Бүгд: 19
21.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 13
Бүгд: 19
31.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 14
Бүгд: 19
26.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хуулийн төслийг хэлэлцүүлэхэд гишүүдийн танхимд байгаа ирц хангалтгүй байгаа тул уг асуудлыг хэлэлцэх асуудлаас хойшлуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Горимын санал дэмжигдээгүй тул уг асуудлыг хэлэлцэхээр тогтов.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Э.Болормаагийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19

36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2026.04.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд биечлэн оролцох боломжгүй тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах тухай хүсэлт ирүүлж, хуралдаан даргалагч уг асуудлыг хойшлуулав. /16:29/

Найм.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Болормаа, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Да.Цогтбаатар нар үг хэлэв.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 10

Бүгд: 19

47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Байнгын хорооны 32 гишүүнээс 17 гишүүн ирцдээ орж, хурал эхлэхэд бэлэн болсон байна 53,1 хувийн ирцтэй байна. Уучлаарай, нэрээр нь уншиж танилцуулах юм байна шүү. 17 гишүүн хуралдааныхаа ирцэд орсон байна.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Жигжидийн Батжаргал, Сандагийн Бямбацогт, Болдын Жавхлан, Бөхчулууны Пүрэвдорж, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Бат-Эрдэнэ, Баярмагнайн Баярбаатар, Амгаланбаатарын Ганбаатар, Лхагвын Мөнхбаатар, Чинбатын Ундрам, Доржзовдын Энхтуяа, Батын Батбаатар, Энхбатын Болормаа, Лувсаннъямын Гантөмөр, Жудагийн Баярмаа гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн Нямтайширын Номтойбаяр гишүүн. Ингээд 18 гишүүн боллоо. Ингээд хуралдаан эхлэхэд бэлэн боллоо. Танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар нарын 10 гишүүн 2025 оны 11 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

2. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 4 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай/

4. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 40 гишүүн 2025 оны 6 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх үргэлжилнэ

5. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025 оны 11 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

6. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин 2025 оны 12 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

7.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал нарын 4 гишүүн 2026 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

8.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2026 оны 4 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

9.Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 2026 оны 5 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Амгаланбаатар гишүүний микрофоныг нээе.

О.Амгаланбаатар: Хуулийн төсөл санаачлагчидтайгаа бас ярилцаад, манай санаачилсан хуулийн бас зарим заалт нь Отгонбаяр нарын гишүүд бариад батлагдчихсан байгаа учраас эргэж бас эндээс өөрчлөлт оруулах шаардлагатай болчихлоо. Тийм учраас энэ хуулийг татаж байна. Эргүүлэн татаж байна. Хойшлуулж өгнө үү. Нэмэлт засвар хийх шаардлагатай байгаа учраас.

Б.Жавхлан: Амгаланбаатар гишүүнд баярлалаа. Тэгвэл өнөөдрийн хэлэлцэх асуудлаас саяын Амгаланбаатар гишүүний дурдсан өргөн барьсан эхний асуудал буюу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлууллаа.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцэх эсэх асуудал

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан “жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ” гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл дээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны гишүүд анхааралтай ажиллаарай. 18 гишүүнээс дөнгөж 5 гишүүн бэлдсэн байна шүү. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтад бэлдэнэ үү. Бат-Эрдэнэ гишүүн, Баярбаатар гишүүн, Баярмаа гишүүн, Бямбацогт гишүүн, Ганбаатар гишүүн, Гантөмөр гишүүн, Номтойбаяр гишүүн, Пүрэвдорж гишүүн, Ундррам гишүүн, Хэрлэн гишүүн, Энхтуяа гишүүд санал хураалтад бэлдэж, санал хураалтынхаа төхөөрөмжийг идэвхжүүлнэ үү. Баярбаатар гишүүн, Баярмаа гишүүн, Бямбацогт гишүүн, Ганбаатар гишүүн, Гантөмөр гишүүн, Номтойбаяр гишүүн, Пүрэвдорж гишүүн, Ундррам гишүүн таных идэвхжээгүй байна. Хэрлэн гишүүн, Энхтуяа гишүүн, Баярбаатар гишүүн, Бямбацогт гишүүн, Ганбаатар гишүүн, Номтойбаяр гишүүн, Пүрэвдорж гишүүн, Хэрлэн гишүүн, Энхтуяа гишүүдийн 7 гишүүн ирцэд идэвхжүүлээгүй байна шүү. Санал хураалтад бэлэн боллоо.

1.Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд нарын 13 гишүүн 2026 оны 5 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрсөн байна. Тэгээд та ямар саналтай байгаа юм? Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Сая санал хураалтад би буруу саналаа дарчихлаа. Тийм учраас саяын саналыг хүчингүй болгоод, дахин санал хураалгаж өгнө үү. Ер нь тэгээд хэлэлцэх асуудлаа ярихаасаа өмнө энэ хэлэлцэх асуудлын жагсаалтад орж байгаа хуулийн төслүүдээ Байнгын хорооны гишүүдэд өгсөн баймаар байна. Тэгж байж бид нар Жавхлан дарга аа, тэгж байж бид нар хэлэлцэх асуудалдаа энэ асуудлыг нэмэх үү, үгүй юу гэдэг шийдвэрээ гаргаж байхгүй бол ингээд алдаа гараад байна.

Б.Жавхлан: Тэгье. Гантөмөр гишүүн зөв санал гаргаж байна шүү. Энэ уг нь бай Эдийн засгийн байнгын хорооноос манай Байнгын хорооны гишүүдэд тарааж өгөх ёстой юм байна. Тэгээд одоо цаашдаа манай Байнгын хорооны ажлын албаныхан өөрийнхөө Байнгын хорооны гишүүдэд өөр Байнгын хорооноос ирсэн асуудлуудыг тусад нь нэмж тарааж өгч, урьдчилж мэдээллээр хангах ёстой шүү. Энийг анхаараарай. Тэгэхгүй бол бас яг ийм асуудлууд цаашдаа гарахыг үгүйсгэхгүй шүү.

Гантөмөр гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжсэнээр 55,6 хувийн саналаар Гантөмөр гишүүний санал дэмжигдэж, саяын санал хураалт хүчингүй боллоо.

Дахин санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт санал хураалтад 18 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж 61,1 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа нарын 19 гишүүн 2026 оны 5 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай санал хураалт. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Засгийн газраас 2026 оны 5 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 14 гишүүн зөвшөөрч, 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа орёе.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир хийнэ. Сандаг-Очир гишүүний микрофоныг нээе.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.” гэснийг “Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан Монгол Улсын уугуул иргэнийг 6 жилийн хугацаагаар зөвхөн 1 удаа сонгоно” гэж өөрчлөн найруулсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн холбогдох заалтыг нийцүүлэх шаардлага гарсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана гэж заасан бөгөөд уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2020 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 02 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөний 2.3-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль шинэчилсэн найруулгын төслийг 2020 онд багтаан боловсруулах, ингэхдээ Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх чиглэл баримтлахаар заасан.

Түүнчлэн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтад хууль тогтоомжийг 2019 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар боловсруулж, Засгийн газрын 2021 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос дээрх тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 8/1823, 3 дугаар сарын 30-ны өдрийн 8/2512, 10 дугаар сарын 16-ны өдрийн 10/4381, 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 10/2775, 8 дугаар сарын 20-ны өдрийн 10/7396 дугаар албан бичгийг Засгийн газарт Төрийн байгуулалтын байнгын хорооноос тус тус хүргүүлж байсан.

Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтож, шийдвэрлэсэн боловч эдгээр хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

Үндсэн хуулийн цэц 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцээд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна гэж заасны 4 жил гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн 1 удаа сонгоно гэснийг зөрчсөн байна гэж дүгнээд, мөн өдрөөс 4 жил гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн болно.

Байнгын хорооны гишүүд та бүхнийг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Лувсаньямын Гантөмөр гишүүнээр тасаллаа. Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Их Хурлын удирдлагаас 2 асуулт байгаа.

1 дүгээрт энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараа хийгдэх учиртай Ерөнхийлөгчийн тухай хууль яагаад өөрчлөгдөхгүй байгаа юм бэ. Тэгээд үүнээсээ болоод Үндсэн хуулийн зөрчил хүртэл өнөөдөр гараад явж байдаг. Тэгээд энэ ажлыг хэн хийх учиртай юм бэ гэдэг дээр өнөөдөр их тодорхой хариулт өгмөөр байна. Ганц энэ заалт бол ерөөсөө биш. Монгол Улсын Ерөнхийлөгч хэн байх, юу хийдэг хүн байх, ямар цар хүрээнд ажиллах, магадгүй ямар үр дүн гаргах гээд бүх зүйлийг бол бид нар хуульчилж өгөх учиртай. Тийм биз. Тэгээд Их Хурал өөрөө ажлаа хийхгүй болохоор энэ улс чинь нэг тийм эзэнгүй айл болчихоод байна шүү дээ. Тэгээд одоо Их Хурлын гишүүн нь очоод хуульд өөрчлөлт оруулаагүйн хариуцлагыг хүлээгээд, тэнд Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч болоод, асуултад хариулаад зогсож байна гэдэг бол бид нар үнэхээр аймаар учир дутагдалтай байгаа байхгүй юу.

Тийм учраас Жавхлан дарга одоо яаралтай ажлын хэсэг гаргаад, Ерөнхийлөгчийн хуулийг өөрчлөх ажлыг яаралтай хиймээр байна. Энэ дээр маш тодорхой хариултыг Бямбацогт даргаас авч, Төрийн байгуулалтын байнгын хороонд өгмөөр байна. Тэгээд бид нар ажлаа хийхгүй болохоор хуулийн гадуур асуудал үүсдэг. Магадгүй ингэж явж байгаад улсынхаа Ерөнхийлөгчийг Үндсэн хууль зөрчсөн хүн болгож хувиргах бас асуудлууд их олон харагдаад байгаа шүү. Тэгээд энэ дээрээ тодорхой шийдэл гаргахыг Их Хурлын удирдлагаас албан ёсоор хүсэж байна. Тамгын газар ажиллах юм уу, бүлгүүд ажиллах юм уу, манай Төрийн байгуулалтын байнгын хороо ажиллах юм уу. Хэн ажиллах юм. Эзэнтэй болгоод Ерөнхийлөгчийн хуулийг яаралтай батлах хэрэгтэй. Ийм саналыг албан ёсоор гаргаж байна. 1 дүгээрт.

2 дугаарт яг энэ Цэцийн бүрэн эрхийн асуудал баталгаатай юу. Цэцийн дарга нь хугацаа нь дуусаад 1 жил болж байгаа. Баясгалан билүү. Цэцийн 1 гишүүнээ татаад авчихсан. Энийгээ хэзээ шийдэх юм. Одоо Цэц бүрэн бус бүрэлдэхүүнээр магадгүй Их суудлын хуралдаан хийх юм бол хууль бус шийдвэр гаргахаар байгаа юм. Тэгэхээр бид бол ингээд өөрснөө ажлаа цаг хугацаанд нь хийхгүйгээс болоод Цэцийг хүртэл хамгаалалтгүй болгож байгаа юм. Хууль бус зүйл рүү түлхэж байна. Жишээлбэл, одоо Цэцийн дарга улс төрийн тохироо хийгээд, улс төрийн шийдвэр гаргахад бэлэн болчихоод байгаа юм. Дараагийн албан тушаалаа тохирчихно.

Ингээд буруу шийдвэр гаргана. Тэрийг нь засах гэж Их Хурал бөөн юм болно.../минут дуусав/

Б.Жавхлан: Гантөмөр гишүүн санал хэлчихсэн үү. Асуулт биш. Ажлын албаныхан саяын Гантөмөр гишүүний хэлсэн зүйл дээр анхаарал хандуулаарай. Надад цаасан дээр буулгаад өгөөдхөөрэй. Оюунсайханы Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Баярлалаа. Тэгээд бид нар цэц гээд ийм ямар ч тийм цэгцгүй газартай болсон. Даргынх нь, гишүүдийнх нь хугацаа дуусчихсан. Тэгээд л янз янзын шийдвэр гаргаад сууж байдаг. Одоо сүүлдээ ер нь Цэц чинь хэм хэмжээ тогтоох гээд байна шүү дээ. Их Хурал яаж шийдэх юм. Тодорхой хугацаа давтамжийн талаар хэд гэж заах юм. Энийг бүр та нар ингэж шийдээгүй нь буруу гэж бид нарт бүр хэм хэмжээ тогтоох гээд байна шүү дээ. Үгүй ээ, эд нарт ийм эрх байхгүй.

Монгол Улсын Үндсэн хууль болоод бусад хуулиар цэцийн хууль, бүх хуулиар ийм эрх хэмжээ байхгүй. Одоо ингээд ийм дураараа шийдвэрээ гаргаж байдаг улс төрийн улаан булан гэдэг шиг ийм Цэц нэртэй цэгцгүй байгууллагатай боллоо. Хууль нь хуучирчихсан. Өнөө цагийн шаардлагыг хангахаа байчихсан. Зөндөө олон алдаа дутагдал гардаг. Өөрсдөө хуулиа хэрэгжүүлдэггүй, тэгээд сайхан хууль бариад суудаг ийм байгууллага. Ялгаа байхгүй энэ Ерөнхийлөгчийн тухай хууль нь бас шинэчлэх шаардлагатай хуучирчихсан. Өнгөрсөн парламентаас авхуулаад өнөөгийн Ерөнхийлөгчийг сонгогдсоноос хойш энийг өөрчилье, өөр болгоё, Үндсэн хуультайгаа нийцүүлбэ гэж ярих, зүрхлэх зоригтой хүнгүй болчихсон. Бүгдээрээ айцгаагаад л, хуруу гараа гозойлгож энэ хүн гэж яриад л, пялдагадаад л. Харин ч энэ хүн өөрөө парламент ёсны туршлагатай улс төрч учраас хугацаагаа сунгахгүй, надад тийм бодол байхгүй гэж хэлээд, парламент ёсоо хүндэлнэ гэж хэлээд байж байна. Бүр үнэхээр эргэлзтэл нь вакумжуулаад хуулийг нь ч өөрчлөхгүй. Энэний чинь цаана 1 хувь хүний асуудал биш бүтэн институцийн асуудал доголдоод болохгүй байгаа юм.

Өнөөдөр энэ хуучин Үндсэн хуулийн үед хугацааг нь заачихсан хуулийг өнөөдөр бид нар Үндсэн хуультай зөрчилдсөн зөрчилтэй гээд яриад суух утгагүй шүү дээ. Угаасаа зөрчилдөж байгаа. Зөрчилдөнө. Энэ бол хэн нэг хувь хүний асуудал биш. Үе үеийн Ерөнхийлөгчийн үед ингээд иймэрхүү л байсан. Бүх үеийн Ерөнхийлөгчийн хувьд. Одоо харин бид нар энийг хурдан түргэн баталж залруулахгүй бол 6 жилийн хугацаатай сонгогдох Ерөнхийлөгч дахиад сонгогдоно. Тэгээд Ардчилсан намаас дэвшиж магадгүй хүмүүсийг, магадлалтай хүмүүсийг бол шорон оронд хориод л байгаа юм. Тэгэхдээ 50 наснаас дээш дэвших потенциалтай Ардчилсан намын бүх хүнийг багтаах шорон Монголд байхгүй л дээ. Эрүүл шударга өрсөлдөөн гарах байх. Тэгээд бол энэ сонгуульд бол хэн ч ялж болно. Гагцхүү бид хүнд биш, системд зориулж энэ хуулиа шинэчлэх шаардлагатай болчихсон байна гэдгийг л өнөөдрийн энэ үйл явдал харуулаад байгаа шүү.

Тэгээд энэ дээр бол хэлээд байх зүйл байхгүй. Зөрчилдсөн. Хуулиа хурдан засаж сайжруулцгаая.

Б.Жавхлан: Гишүүн санал хэллээ. Гишүүд. Цэцийн дүгнэлттэй холбоотой асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. Баярбаатар гишүүн, Баярмаа гишүүн, Болормаа гишүүн, Бямбацогт гишүүн, Номтойбаяр гишүүн, Пүрэвдорж гишүүн, Хэрлэн гишүүн, Энхбаяр гишүүн, Энхтуяа

гишүүд ирцэд санал хураалтад бэлдэнэ үү. Идэвхжээгүй байна шүү. Баярлалаа. Санал хураалт.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна.” гэж заасны “... 4 жил” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгчөөр ... 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 14 гишүүн зөвшөөрч, 77,8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн танилцуулах вэ. Доржзовдын Энхтуяа гишүүн өөрөө саналаараа танилцуулъя гэж байна.

15.07 цаг.

Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 40 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийе.

2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар тус хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийх үед Монгол Ардын намаас ажлын 5 өдрийн завсарлага авсан бөгөөд завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Монгол Ардын намын бүлгийн даргын зүгээс хэлэх үг байна уу. Байхгүй байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ хэмээн зааснаар Монгол Улс байнгын ажиллагаатай нэг танхим бүхий парламентын Бүгд Найрамдах Улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна.

Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно. Парламентын

ардчилал нь нээлттэй, тэгш чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бөгөөд парламент ёс нь парламентаас Ерөнхий сайдыг томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ.

Монгол Улсын Их Хурал нь 126 гишүүнтэй төрийн эрх барих дээд байгууллага боловч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс гадна Ерөнхий сайд тусгайлсан суудал эзэгнэж, хуралдаан даргалагчийн түвшинд танхимын хойморт байрлаж буй нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд үл нийцэж байна.

Тиймээс парламентын ардчиллыг баталгаажуулахын тулд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Улсын Их Хурал дахь олонх ба цөөнхийн тэгш мэтгэлцээнээр явагддаг чуулганд гишүүд сонгогч иргэдээ төлөөлөн байр сууриа нээлттэй илэрхийлж үгээ чөлөөтэй хэлдэг байхын сацуу хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй хэрэгжих парламентат ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Парламентын нийтийн танхимын гол философи нь засгийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй байдаг гэдгийг бэлгэддэг. Нийтийн танхим дахь суудлын байршил нь олонх эрх мэдэл ба цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй хуралдаж шийдвэр гаргах үндсэн зорилгод зориулагдсан байдаг. Танхимд онцгойрох спикерийн суудал нь хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэртэй, сонирхлын зөрчилгүй хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хурлын дэгийг сахиулах, парламентын дархлааг хамгаалах үүргийг хариуцан ажиллах байдлыг илтгэдэг. Ардчиллын зарчим буюу хагас дугуй болон дугуй суудлын байрлал нь нам харгалзахгүй хэлэлцүүлэгт уриалан дуудах зорилготой бөгөөд олонх, цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангах ёстой. Танхимын байрлал бол зөвхөн архитектур биш ба улс төрийн соёл, шийдвэр Үндсэн хуулийн дэг журамтай холбоотой нөхцөл байдал юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд улс төрийн чөлөөт өрсөлдөөнд мэтгэлцээний талбар байх зарчмыг тэр бүр хангадаггүй. Тэр байтугай чуулганы хуралдааны танхимд зохион байгуулалтын бүдүүвч, зураг, байршлыг ямар субъект батлах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Тиймээс 1992 оноос хойш Улсын Их Хурлын дэд дарга сайн дураараа уг зураглал байршлыг баталж ирсэн нь хамгийн сүүлд Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа баталсан нь одоо мөрдөгдөж байгаа ажээ.

Тиймээс уг асуудлыг цэгцлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах практик шаардлагатай байна гэж үзлээ.

Хуулийн төслийг хэлэлцэж өгнө үү.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэлийг Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн танилцуулж дууслаа. Илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Батын Батбаатар гишүүнээр, Жигжидийн Батжаргал гишүүнээр тасаллаа. Батбаатар гишүүний микрофоныг нээе.

Б.Батбаатар: Хууль санаачлагчаас 1 зүйл асууя. Одоо өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, энэ хуулиудад дандаа нам, эвслийн бүлэг гэж яваад байгаа. Улс төрийн нам бол төрийн сонгуульд оролцож болдог, иргэдийн эвлэлдэн нэгдсэн, тусдаа хуультай улс төрийн байгууллага. Тэгэхээр бүлэгтэй биш бол улс төрийн байгууллагынхаа хувьд энэ Улсын Их Хуралд бас иргэд олон нийтийн тодорхой хэмжээний дэмжлэг аваад ороод ирчихсэн улс төрийн намуудад яагаад энийг нь дандаа ингэж орхигдуулж явах, ер нь орхигдоод байна гэдэг нь буруу гэж зарим нь яах вэ, өнөөдөр Ардын нам, Ардчилсан нам өөрсдөдөө зориулж хуулиа санаачлаад, өөрсдөдөө зориулж батлаад байгаа. Тэгэхээр хууль санаачлагчийн зүгээс эндээс энэ 1 зүйл дээрээ жоохон анхаарахгүй юм уу. Хэрвээ энэ дээрээ нам гэдэг төлөөллийг нь бас хангах тухай орж ирээд яах вэ, бүлгийн тэр айхтар олон зарим эрх мэдлийг бүгдийг нь авах гээд байх алба байхгүй. Эрх мэдлийн гэхээсээ илүү улс төрийн нам гэдэг эрхээ олж авч, парламентын чуулганы үйл ажиллагаанд оролцож байх нь зүйтэй гэж ингэж үзээд байгаа шүү дээ.

Сая энэ Улсын Их Хурлын тухай, Дэгийн тухай, Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийн төслийг Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр яриад үндсэндээ санаачилсан гишүүд нь зөвхөн Ардын нам, Ардчилсан намын гишүүд л байгаа. ХҮН намаас ороогүй, Иргэний зориг ногоон намаас төлөөлөл орж, санаачилгад нь ороогүй. Яагаад вэ гэхээр саналуудыг аваагүй учраас санаачлагчаар ороогүй. Тэгэхээр энэ зүйлийгээ хэдүүлээ бодож, хамтдаа явах тухай бодож болохгүй юу. Хэрвээ энэ боломжгүй, та нар зөвхөн бүлэгтэй тохиолдолд намын улс төрийн эрхээ эдэл гэж байгаа бол энийг хэлэлцэх асуудал дэмжихгүй байх байр суурьтай орохоос л өөр замгүй болох юм.

Б.Жавхлан: Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Энэ хуулийн зорилго ерөөсөө ганцхан зорилготой. Тэр нь юу вэ гэхээр Үндсэн хууль дээр байж байгаа: Улсын Их Хурал 126 гишүүнээс бүрдэнэ. Чуулганы хуралдааны зохион байгуулалт нь энэ 126 гишүүн хуралдахад зориулагдах ёстой. Гэтэл чуулганы хуралдааны танхим дотор Ерөнхий сайдад тусгайлан суудал бэлдээд, Улсын Их Хурлын тархин дээр гаргаад тавьчихсан байгаа. Үндсэн хууль дээр маш тодорхой заасан. Улсын Их Хурал, Ерөнхий сайдыг томилно, огцруулна. Ерөнхий сайд хуулийн биелэлт буюу ажлаа Улсын Их Хуралд хариуцан тайлагнана. Гэтэл Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг этгээд нь өөрөө спикертэй зэрэгцээд Улсын Их Хурлын даргалагч маягтай тэр дээр гарч суугаад, тэгээд тэр дээр гарч суусан байдлаасаа болоод Улсын Их Хурлын гишүүдийг дээрээс доошоо зандагчсан байдлаар үг хэлдэг. Тэгээд энэ байдлыг л зогсоох зорилготой. Тэгээд бусад улс орнуудад бол Ерөнхий сайдад тусгайлан яг энэ дээшийгээ спикертэй өрсөлдөхүйц талбар дээр сандал засаж өгдөггүй юм байна лээ.

Харин парламент олон намын тогтолцоо бүхий нөгөө цөөнх, олонх сөрөг хүчин, эрх баригч гэдэг энэ харьцаан дээр байдаг учраас парламентын засаглал бүхий улс орнууд Ерөнхий сайдыг цөөнхийн лидертэй мэтгэлцэх 2 өөдөөс нь харуулсан байдалтайгаар сандлыг нь шийдэж өгдөг юм байна лээ. Тэгэхээр манайх хагас дугуй парламентын чуулганы зохион байгуулалттай учраас Ерөнхий сайд Улсын Их Хурлын асуулгын цаг дээр зөвхөн энд зориулсан хууль. Энэ хууль өөр юм руу халиагүй.

Б.Жавхлан: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Хууль санаачлагч Тэмүүжин гишүүн нарын хүмүүс энэ оруулж ирж байгаа саналыг дэмжиж байгаа. Гэхдээ өөрөө 1 зүйлийг уншаадхаач. 15.7-г. Би дундаас нь уншчихъя.

“Цөөнхийн бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд дарга тухайн цөөнхийн бүлгийн дарга нарын суудлыг нүүрний эгнээнд тус тус хуваарилна.” гэхчхэн байгаа. Бүлэггүй буюу зөвлөлийн дарга гэж нэрлэнэ үү, юу гэж нэрлэнэ үү, тэр намын дарга гэж нэрлэнэ үү, тэр хүмүүсийн суудлыг хуваарилах тухай бичигдээгүй байгаа байхгүй юу. Би тэр тухай л хэлж байгаа. Ингээд дотор нь битгий орхиод, дараа нь бид нар асуудал ярихаар Дэгийн тухай хууль дээр ийм юм байгаа юм. Олонх, цөөнх гэж байдаг. Олонх, цөөнхийн бүлэг л гэж байдаг. Засагт ороогүй цөөнх энэ тэр гэдэг тийм юм байдаггүй юм гээд ингээд яриад эхэлдэг шүү дээ. Тийм болохоор тэр үгийг нэмж оруулах уу, оруулахгүй юу л гэж асуугаад байгаа юм. Жишээ нь, энэ чинь их ойлгомжтой асуучихлаа шүү дээ.

Б.Жавхлан: Тэмүүжин гишүүний микрофоныг нээе. Хариулт өгье.

Х.Тэмүүжин: Хуулийн төсөл өргөн баригдсантай холбоотойгоор хэлэлцүүлгийн явцад энэ дээр ийм үг оруулъя гээд зарчмын зөрүүтэй санал гаргах нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх шүү дээ. Тэгээд зарчмын зөрүүтэй саналаа гаргаад, дэмжих, дэмжихгүй чинь тэрний дараагийн асуудал байлгүй дээ. Би бол одоо Улсын Их Хурлын хууль дээр байж байгаа 15.7-г хардаа. Цөөнх болсон бусад нам, эвслийн бүлгийн гишүүд, бүлэггүй цөөнхийн гишүүдийг дараагийн суудлуудад хуваарилах гээд л биччихсэн байна шүү дээ. Өөр ямар үг бичих юм. Энэ чинь суудал хуваарилах л юм байхгүй юу. Болно шүү дээ. Дахиад 1 минут өгчих. Бид энэ хэлэлцүүлгийн явцад .../минут дуусав/

Б.Жавхлан: Тэмүүжин гишүүн дахиад 1 минут.

Х.Тэмүүжин: Бид хэлэлцүүлгийн явцад бусад улс орнуудын парламентын туршлагыг хараад энэ суудлын хуваариа хийх боломжтой шүү дээ. Жишээ нь Батбаатар даргын хэлж байгаа шиг Швейцарт улс төрийн намын дарга нар чинь хамгийн хойд талын эгнээнд суудаг юм байна лээ шүү дээ. Гишүүдээ хянах зорилготой.

Б.Жавхлан: Тэмүүжин гишүүн таны минут яваад байна шүү.

Х.Тэмүүжин: Заавал нүүрний эгнээнд дарга нар сууна гэж байхгүй юм байна лээ шүү дээ. Тийм учраас ийм санаачилгыг гаргаад, санал хураагаад олонхоороо шийдээд явахад нээлттэй шүү дээ.

Б.Жавхлан: Хариулт өгч дууслаа. Жигжидийн Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Монгол Улс энэ ардчилал парламентын засаглал руу шилжээд үндсэндээ 34, 35 жил болчихжээ. Тэгээд энэ хугацаанд нэг тогтчихсон тийм ойлголт бий болчихсон юм байна. Тэгээд өнөөдөр энийг өөрчилье гээд хууль оруулаад ирж байгаа юм. Энэ талаас нь харвал Ерөнхий сайд тусгайлан сууснаараа парламентын ардчилал ямар сөрөг нөлөө үзүүлдэг юм. Би бол ойлгохгүй байгаа. Ер нь төр гэж юу юм бэ гэж. Энэ бас улс орнуудын шууд практикийг авч ашиглана гэх нь уг үндэстний өөрийнх нь язгуур оюун санааны ойлголттойгоо л нэгдмэл байх тухай л ойлголт л доо. Тэрнээс соёолдоггүй

юмнуудыг авчирч соёолуулах гэж оролдоод бол хэрэггүй. Ер нь бидний урагшаа олигтой алхаж өгөхгүй байгаад байгаа энэ тэр юмнууд чинь бол үндэстний оюун санааны нэгдмэл үнэт зүйл нь жоохон сарниад байгаа юм биш үү гэдэг ийм ойлголт байгаад байгаа юм. Тийм учраас би бол энэ талаасаа ер нь юмаа харцгаавал яасан юм бэ дээ гэдэг ийм зүйл байгаад байгаа юм.

2 дугаарт энэ Улсын Их Хурлын хуульд энэ суудал хуваарилдаг юмыг хуульчлан тусгаад байх эрх зүйн зайлшгүй шаардлага практик хэрэгцээ нь юу байгаад байгаа юм бэ. Энэ Их Хурлын удирдлагын гэдэг юм уу энэ бүтэц нь өөрөө тогтоогоод явж болохгүй юм уу. Би энэ талаас нь л асуумаар байна л даа. Юу гэж ойлгоод байна вэ. Ер нь бол Их Хурлын үйл ажиллагааг энэ парламентын засаглалыг төгөлдөржүүлэх, парламентын ардчиллыг хөгжүүлэх чиглэлээр жилээс жилд ахицууд яваад байгаа. Энэ Улсын Их Хурлын асуулгын цаг гэдэг бол ёстой. Ерөнхий сайдыг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн бүлгүүдээс, гишүүдээс асуулт асуух тэгш байх гэдэг юм уу, тэр зарчмыг нь хангаад, сүүлийн жилүүдэд энэ мэтгэлцээний зарчмыг бий болгосон. Үүгээрээ дамжаад бүх юм нь явах ёстой.

Харин Ерөнхий сайдыг Улсын Их Хурал томилдог нь үнэн. Тэгвэл тэр үйл ажиллагааг нь зохицуулсан хууль талдаа л суулгах ёстой гэдэг юм уу, дутуудуулчихаад байгаа зүйлүүдээ анзаарах ёстой бид. Тэрнээс хэлбэр талаасаа ч би бол тэгж ойлгохгүй л байгаад байгаа л даа.

Б.Жавхлан: Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Энэ бол тийм хэлбэр талын юм ерөөсөө биш шүү дээ. Энэ сандал суудлын асуудал ч ерөөсөө биш. Монгол Улсын Үндсэн хуульд байгаа үзэл санааг энэ Улсын Их Хурлын чуулганд амилуулах уу, үгүй юу гэдэг асуудал шүү дээ. Та үндэстний оюун санааны нэгдмэл байдал гэж хэлж байна. Монгол Улсын Үндсэн хууль Монголын ард түмний нийгмийн гэрээ шүү дээ. Энэ оюун санааны чинь нэгдмэл байдлыг Монгол Улсын Үндсэн хууль өөрөө тодорхойлж байгаа шүү дээ. Гэтэл Үндсэн хууль руугаа нулимаад сууж байж болохгүй шүү дээ. Монгол Улсын Үндсэн хууль дээр Ерөнхий сайд Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнана. Ажлаа хариуцан тайлагнах гэж байгаа хүн нь Улсын Их Хурлын толгой дээр гарч суучаад, Оюун-Эрдэнэ шиг Баярмаа гишүүнийг доромжлоод сууж байж болохгүй шүү дээ. Тэр суудал нь Ерөнхий сайдыг энэ Улсын Их Хурлын гишүүдийг доромжилж болно гэдэг тийм уур амьсгалыг бий болгож байгаа шүү дээ. Яг феодал шиг, ноён шиг хээ хуартай суудал дээр Ерөнхий сайд нь Улсын Их Хурал, парламентынхаа чуулган дотор суудаг улс дэлхийд байхгүй шүү дээ. Парламентад Ерөнхий сайд, сайд нар нь тусдаа суудалтай байдаг улсууд байна. Парламентын гишүүдийнхээ өөдөөс харуулаад, тэнд нэг зарчим үйлчилж байна. Тэр нь юу вэ гэхээр энэ суудал дээрээс парламентад худлаа хэлж болохгүй шүү гэдэг зарчим үйлчилж байгаа шүү дээ. Тэгснээс биш Улсын Их Хурлын гишүүдтэй адилхан хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй шүү гэдэг зарчим нь үйлчлэхгүй байгаа шүү дээ. Энэ зарчмыг үйлчлүүлэхийн тулд Ерөнхий сайд, сайд нарыг тусад нь суулгаж байгаа юм. Тэгснээс биш Улсын Их Хурлыг даргалж байгаа юм шиг спикерийн хажууд хээ хуартай сандал суудал бэлдэж өгөөд Ерөнхий сайдаа суулгадаг улс дэлхийд байхгүй. Үндсэн хуульд ёс энийг шаардаж байгаа шүү дээ.

Монгол Улс эрх мэдлийг хуваарилсан улс. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэдэг эрх мэдэлтэй. Гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн нь Ерөнхий сайд. Ерөнхий сайдыг Засгийн газрын хурлаа удирдаж байхад нь спикер хажууд нь сандал тавиад сууж болохгүй шүү дээ. Яг тэрэнтэй адилхан Улсын Их Хурлын дарга спикер хурлаа

удирдаж байхад Ерөнхий сайд хажууд нь зэрэгцээд, сандал ширээ тавиад сууж байж болохгүй байхгүй юу. Ерөнхий сайдыг доош нь оруулж ирээд, гишүүнийх нь суудал дээр суулгана. Гишүүнийх нь суудал дээр суухгүй бас жоохон тусдаа баймаар байна гэвэл Ерөнхий сайд, сайд нарыг тусад нь 1 бүлэг болгож суулгаад, энэ сандал дээрээс Улсын Их Хуралд худлаа ярихгүй шүү гэдгийг нь зааж өгөх хэрэгтэй шүү дээ. Сая та хэд завсарлага аваад Улсын Их Хурлын гишүүн биш Ерөнхий сайдаа хаана суулгах вэ гэдэг зовлонтой байна л гэж хэлсэн шүү дээ. Улсын Их Хурлын биш Ерөнхий сайд бол бүр Улсын Их Хурлын тархи дээр сууж болохгүй шүү дээ. Ажлын хэсгийн суудал дээр сууна шүү дээ. Танай намын зовлон энэ парламентын зовлон болж болохгүй шүү дээ. Би бол ийм л байр суурьтай байна.

Б.Жавхлан: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Энд намын зовлон Их Хурал руу оруулж ирж байгаа юм байхгүй. Тэр талаасаа яримгүй.

2 дугаарт тэр Улсын Их Хурлын гишүүнтэй Засгийн газрын тэргүүн харьцах, ажлаа тайлагнах энэ тэр бол тусдаа асуудал. Суудлаас хамааралтай тийм юм гэж байхгүй та минь. Одоо бас зөв ярьцгаах ёстой. Тийм учраас би энэ Монголын парламентын засаглал үүсээд 30 гаруй жил явчихсан энэ түүхэн хөгжлийнх нь хугацаанд энэ суудал зохиогүйгээсээ болоод урагшлаагүй энэ тэр гэж би ойлгохгүй байгаа. Яг үнэнийг хэлэхэд тэрнээс болоод парламентын засаглал төгөлдөржих гэдэг юм уу, парламентын ардчилал хөгжих гэдэг юм уу энэ үйл явцад садаа болоогүй. Бид эрх зүйн орчноо жилээс жилд боловсронгуй болгоод явж байгаа. Бид энэ мэтгэлцээний зарчим гэдэг юм уу энэ юмнуудаа .../минут дуусав/

Б.Жавхлан: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Ер нь бол энэ хуулийг өргөөд жил болж байгаа. Өргөн бариад. Оюун-Эрдэнийг Ерөнхий сайд байхад эхэлсэн. Дараа нь Занданшатар Ерөнхий сайд байхад үргэлжилсэн. Одоо Учрал Ерөнхий сайд байхад хэлэлцэж байгаа. Энэ өөрөө парламентын бол амин сүнс. Парламент бол 126 гишүүн, Улсын Их Хурал бол 126 гишүүнээс бүрдэнэ. 126 гишүүн хуралдаж шийдвэр гаргахад зориулж энэ чуулганы танхим зохион байгуулагдах ёстой. Улсын Их Хурал хууль тогтоох, төлөөлөх, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхэд зөрчилдөхгүйгээр чуулганы танхим зохион байгуулагдах ёстой. Гэтэл бид энэ чуулганы танхимыг зохион байгуулах асуудлыг яг үндсэндээ Улсын Их Хурал өөрөө хяналтаасаа гаргачихсан юм байна лээ. Тэгээд ёслолын алба зохион байгуулалтыг шийддэг болоод хувирчихсан. Энэ чинь өөрөө Улсын Их Хурал буюу ард түмний .../минут дуусав/.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Лувсанямын Гантөмөр гишүүнээр тасаллаа. Гантөмөр гишүүнийг микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Би дэмжиж байгаа. Хамгийн гол нь би Их Хурлын гишүүдийгээ энэ хуулийн өөрчлөлтийг дэмжиж өгөөч гэж хүсмээр байгаа юм. Энэ бол ямар нэгэн байдлаар тийм улс төрийн ч юм уу эсвэл нам, эвслийн асуудал ерөөсөө байхгүй. Хамгийн гол нь Монгол парламентын засаглалтай орон цаашаагаа ямархуу байдлаар явах вэ гэдэг дээр Тэмүүжин гишүүн яг хуульч хүний хувьд тийм онцгой

зүйл анзаарсан байгаа. Тэгээд бид нар бас яг энэ мэргэжлийн хүмүүсийнхээ анзаарч байгаа юмыг өөр мэргэжлийн хүмүүс бол ойлгохыг хичээмээр юм байна лээ. Тэгэхээр бол энд Учралын ч юм уу, хэн 1 Ерөнхийлөгчийн асуудал ерөөсөө биш юм шиг байгаа юм. Энэ бол өөрөө Монгол Улс бол парламентын засаглалтай улс шүү гэдгийгээ ингээд байнга ухамсарлаж байх, магадгүй парламентын засаглалтай улсын хувьд яаж энэ засаглалаа хөгжүүлэх вэ гэдэг дээрээ байнга сэтгэл оюунаа чилээж байх монголын хуульчид энэ чиглэлээр ажиллаж байх ийм шаардлага бол Монголд байгаад байна. Бид нар бол ардчилалд дургүй хүмүүс зөндөө л байгаа. Ялангуяа парламентын ардчиллыг эсэргүүцдэг хүмүүс нэмэгдэж байгаа. Тэрийг бол бид нар мэдэж байгаа шүү дээ. Энэ парламентын гишүүд энд тэнд явж байхад хүмүүсийн хэлж байгаа үг бол их өөр болж байгаа. Мэдээж хэрэг парламентын засаглалтай улсад Ерөнхий сайд бол 01 номерын хүн. Бид нар бол өнөөдөр андуураад байгаа. 01 номерын хүнээ бид нар 03 номер болгоод ингээд энэ улс бол ер нь маш их олон юман дээр түүртээд байгаа. Шийдвэр гаргах эрх мэдэлгүй болгосон, бүх хүн шүдгүй арслан болж байгаа. Юм шийдэж чаддаг хүн байхгүй. Сэтгэл байвч хийгээд явахаар буруудчих гээд байдаг, эрх мэдлийг нь өгдөггүй. Яг тэр шиг парламент бол сандал ширээгээ өөрөө мэддэг байх нь бол их зөв. Энийгээ хуульчлах нь бол бүр зөв. Хэн нэгэн хүнээс үл хамаараад бид нар хуульчлах хэрэгтэй. Хэдийгээр номер 1 эрх мэдэлтэй хүн Ерөнхий сайд боловч тэр хүн нь парламентын дээр гарч сууна гэдэг зүйл бол маш буруу. Буруу юм байна лээ. Тэр хүн бол Монголын ард түмнээс сонгогдсон энэ засаглалын хамгийн дээд оргил болсон парламентынхаа өөрт нь хуваарилагдсан суудал дээр суух ийм зайлшгүй шаардлага бол байна. Энэ бол байна. Би бол энийг Тэмүүжин их соргогоор юмыг олж харжээ гэж ингэж бодож байгаа шүү гишүүд ээ.

Тэгэхээр та бүхэн маань гол нь намчирхалгүйгээр энэ асуудлыг хэлэлцэх эсэхийг нь шийдэж байгаад, тэгээд ер нь олон улсын туршлагыг бид нар шууд авъя гээд байгаа юм биш шүү дээ. Энэ чинь одоо манай Монголоор бол Их хуралдай. Их хуралдайгаа бид нар яаж хийдэг байх вэ гэдэг зүйл. Ялангуяа Занданшатар Ерөнхий сайд байхад бол Их Хурлын гишүүн биш Ерөнхий сайд орж ирээд Их Хурлынхаа дээр гараад сууж байгаа нь бол яг парламент засаглал дээрээ бол буруу байгаа байхгүй юу. Аймар буруу харагдаад байгаа юм. Парламентыг хэтэрхий хүчгүй болгож байгаа юм. Тэгээд ингээд яваад байхаар бид нар их олон зүйлийг хийж чадахгүй байна шүү дээ. Жишээ нь Ерөнхийлөгчийн хуулиа өөрчилж чадахгүй байна. Цэцийг цаг хугацаанд нь томилж чадахгүй байна. Шүүхийн асуудлыг бид шийдэж чадахгүй байна. Ядаж одоо Батжаргал дарга минь наадмыг хар л даа. Таны дээр шүүгч сууж байна. Цагдаагийн дарга сууж байна. АТГ-ын дарга сууж байна. Прокурор чинь ирээд суучхаж байна. Цэцийн дарга сууж байна. Тэгээд парламентынхаа дээр тийм олон гүйцэтгэх албаны хүмүүсээ суулгачхаад ямар парламентын улс байх юм хэдүүлээ. Ингээд л буруу л юм их олон байгаа байхгүй юу. Тийм учраас намчирхалгүйгээр би асуудлаа шийдээч ээ гэж гишүүдээсээ чин сэтгэлээсээ хүсэж байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Хуулийн төсөл үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. Хэрлэн гишүүнийх болчихлоо. Гантөмөр гишүүн дахиад нэг үзээдэх үү. Нөгөө гараараа үзэх юм уу. Санал хураалтад дэмжиж оролцоно гэдгээ Гантөмөр гишүүн урьдчилж хэлсэн байгаа. Энийг протоколд тэмдэглэе. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор

санал хураая. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 6 гишүүн зөвшөөрч, 31,6 хувиар санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Саналаараа танилцуулах хүн байна уу. Ариунзаяа гишүүн танилцуулъя.

15.34 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025 оны 11 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танилцуулна.

М.Бадамсүрэн: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг та бүхэнд хийе.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын бусад эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган зохион байгуулалтын бус хэлбэрээр хэрэгжүүлнэ. Мөн зүйлийн 7 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж, асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан эсвэл хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол нууц санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурал хуралдааны дэгээ өөрөө тогтооно гэж заасан нь Монгол Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хэлэлцэхдээ хуралдааны дэгийг өөрөө тогтоох эрхийг олгож өгсөн байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиар Монгол Улсын Их Хурал хуралдааны дэгийг өөрөө тогтоох эрхийг олгосонтой холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр нийт 16 бүлэг, 137 зүйлтэйгээр баталж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар байгуулсан Улсын Их Хурал анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байдаг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг, цаашид хуралдааны дэг гэх тусгайлан зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгийг Улсын Их Хурал өөрөө тогтооно. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 11 дахь хэсэгт тухайн өдрийн

хурал эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсвэл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэж зааж өгсөн боловч хуулиар олгогдсон эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурал дэгээ өөрөө тогтоож, чуулганы хуралдааныг зохион байгуулахад дэгийн томьёололтой холбоотойгоор зарчимд үл нийцэх үр дүн гарч эхэлсэн. Тодруулбал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар санал хураалт явуулах ерөнхий журмыг нарийвчлан зохицуулаагүйн улмаас үр дүн муутай томьёоллоор санал хураалт явуулж буй нь Монгол Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх хийгээд бусад холбогдох хуулийн зарчимтай нийцэхгүй байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын чуулганы хуралдаан хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх асуудлыг хэлэлцэхэд чөлөөтэй, эрх тэгш оролцоог хангах, цөөнхийн эрхийг хүндэтгэх, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой тодорхой байх, олонхын саналаар шийдвэр гаргах зарчимд үндэслэнэ гэж заасан. Гэтэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны санал хураах журмыг холбогдох хуулиар нарийвчилж тодорхойлж өгөөгүйгээс үүдэн зарчимд харшиж, ойлгомжгүй тодорхойгүй байдлыг чуулганд оролцож буй гишүүдийн хувьд төдийгүй ард иргэдэд үүсгээд байгаа юм. Эс тэгвээс хуралдаанд оролцоогүй эсхүл бусад шалтгаанаар хуралдааныг орхиж гарсан гишүүд саналаа өгөөгүйн улмаас эсрэг саналд тооцох байдлаар санал хураах нь олонхын саналаар шийдвэр гаргах зарчимтай нийцэхгүй гэж үзэж байна.

Иймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын ийн бусад эрх, зохион байгуулалт үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурал хуралдааны дэгээ өөрөө тогтооно гэж тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн санал хураах ерөнхий журмыг нарийвчлан зохицуулж, тус хуулийн 10.8 дахь хэсэг гишүүн санал хураалтад оролцохдоо зөвшөөрсөн эсвэл татгалзсан саналын аль нэгийг өгнө гэсний дараа чуулганы нэгдсэн хуралдаанаар асуудлыг шийдвэрлэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг нь дэмжих эсэхээр санал хураана гэж зохицуулж өгөх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Ерөнхий сайд өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч танилцуулсны дараа Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлж, огцруулахаар заасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хуралд танилцуулах хугацааг нарийвчлан зааж өгөх нь зүйтэй байна гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл хэсэгт заасан хугацааг Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх шаардлагатай байна. Энэхүү хуулийн төслүүд батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчим болон Улсын Их Хурлын чуулганы хуралдаан нь хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх, асуудлыг хэлэлцэхэд чөлөөтэй, эрх тэгш оролцоог хангах, цөөнхийн эрхийг хүндэтгэх, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой, тодорхой байх, олонхын саналаар шийдвэр гаргах зарчимд үндэслэнэ гэсэн үндсэн зарчимтай нийцэж, Монгол Улсын Их Хурлын гишүүдийн ирцтэй холбоотойгоор олонхын саналаар асуудлыг

шийдвэрлэх зарчим хийгээд, төрийн хууль дээдлэх засаглах эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэх юм.

Энэхүү өргөн мэдүүлсэн 3 хэсэг, заалтын хамгийн сүүлийнх нь буюу чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан Засгийн газрыг огцруулах эсэхтэй холбоотой заалтад Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт энэ өвөл буюу энэхүү хуулийн төслийг өргөн мэдүүлснээс хойш Цэцээс дүгнэлт гарч, энэ хуулийг өөрчлөх эсэх талаар Их Хурал дээр хэлэлцэж байгааг бас энд танилцуулах нь зүйтэй.

Та бүхэндээ энэхүү хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Тэмүүжин гишүүнээр тасалъя. Чинбатын Ундрам гишүүний микрофоныг нээе.

Ч.Ундрам: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хуулийн төслийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Одоо бид нар Байнгын хороон дээр асуудал ороод

Б.Жавхлан: Ундрам гишүүн ээ, уучлаарай. Та чинь өөрөө хууль санаачлагч юм байна шүү дээ. Хууль санаачлагчийн асуулт асуухгүй. Дараагийн гишүүн Батын Батбаатар гишүүн асуулт асууя. Микрофоныг нээе.

Б.Батбаатар: Энэ нөгөө Ерөнхий сайдын огцруулах эсэх санал хураалтыг л энэ дэгийнхээ хууль дээр өөрчлөх гээд оруулаад байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд энэ анх гаргасан санал гэдгээ яаж ойлгох юм бэ. Ажлын хэсэг юм уу, Байнгын хорооны санал, дүгнэлтийг яах юм бэ гэдэг тухай асуудал гараад ирж байгаа. Тэгээд хэрвээ нэгэнт Байнгын хороо, ажлын хэсэг бусад нь санал болохгүй бол энэ Ерөнхий сайдтай холбоотой энэ асуудлыг заавал ингэж Байнгын хороогоор оруулах шаардлага байгаа юм уу. Тэртээ тэргүй 32-оос дээш гишүүдийн саналаар орж ирж байгаа асуудал шүү дээ. Байнгын хороогоор оруулахгүйгээр шууд элс Улсын Их Хурлаар оруулбал тэр чинь гаргасан саналынхаа дагуу орно л гэсэн үг. Ямар нэг өөрчлөлт, дунд нь ийм ямар нэг саад нэвтэрч гарч наана цаана болох асуудал байхгүй гэж байгаа. Ингэж ойлгох гээд байгаа юм. Нэгд нь.

Дээрээс нь тэр Засгийн газрын гишүүн танилцуулах энэ тэр гээд энэ юу хугацаатай холбоотой зүйлүүд дээр нь Улсын Их Хурал хугацааг нь мөрдөхгүй болчихвол яах юм. Хэлэлцэх ёстой байтал нөгөө хэлэлцэх хугацаагаа давуулаад өнгөрөөчихвөл яах юм бэ. Тэр саналыг хэлэлцэхээ больчих юм уу, яах юм. Энэ дээрээ зохицуулалт нь яаж орж байгаа юм бэ.

Б.Жавхлан: Хууль санаачлагч Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Анх гаргасан санал гэдгийг Үндсэн хуулийн цэц бол их тодорхой тайлбарлаж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл хууль санаачлах эрх бүхий субъект гаргасан саналыг хэлж байгаа. Тэгээд энэ санал маань өөрөө Байнгын хороо гээд мэргэжлийн Байнгын хороогоор ороод, энэ дээр дэмжигдэхгүй гэсэн саналыг нь дэмжээгүйг дэмжье гэдгээр Их Хурал дээр хураагаад байгаа учраас энийг болохгүй гэж Үндсэн хуулийн цэц бол тодорхой дүгнэлт гарсан. Үндсэн хуулийн цэц. Тэгэхээр энэ нь өөр зарчмын зөрүүтэй санал болон бусад гаргаж байгаа санал дээр ч гэсэн адилхан. Их Хурлын гишүүн Батбаатарыг хуулийн төсөл

санаачлаад, санал өргөн мэдүүллээ гэхэд тэр нь Байнгын хороон дээр дэмжигдээгүй бол тухайн гишүүн өөрөө санал гаргаад, Байнгын хороон дээр тэмдэглүүлнэ. Тэмдэглэлд. Энэ санал маань Байнгын хороон дээр унасан ч гэсэн би босоогоор нь буюу дэмжих эсэхээр чуулганы нэгдсэн хуралдаан дээр хураалгая гээд. Тэгээд чуулганы нэгдсэн хуралдаан дээр тэрийг хураалгахаар тэрийг дэмжих эсэхээрээ санал хураагаад, анх гаргасан саналаар нь явъя. Тэгэхгүй бол дунд нь Байнгын хорооны саналаар хураахаар энэ нь ийм ойлгомжгүй байдал, тодорхойгүй байдал үүсгээд байна.

2 дугаарт ирцэд бүртгүүлээд гараад явсан гишүүд маань эс үлдэхгүйгээрээ энэ унасан саналыг босгоно гэдэг ийм ойлгомжгүй байдлыг үүсгээд байна. Энийг залруулъя л гэж үзсэн байгаа гэсэн үг.

2 дугаарт Засгийн газар огцруулах эсэх асуудал бол энэ дэгийн хуулиараа өөрөө мэргэжлийн Байнгын хороогоороо хэлэлцэгдээд явах тэр горимоороо бол явна. Тэрийг бол бид нар хөндөөгүй. Ерөнхий зарчмын асуудлыг ярьж байгаа. Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөхтэй холбоотой зүйл дээр өмнө нь бол бас нэг кэйс гарсан байгаа. 1 сар орчим бол энэ асуудал хэлэлцэгдээгүй. Тэгэхээр энийг нөгөө Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч сонгуулийн үр дүнгээр Их Хуралд оруулж ирэхдээ ажлын 5 хоногийн дотор гэж зааж өгсөн байгаа. Тэгэхээр үүнтэй адилхан хэрвээ Ерөнхий сайд томилох, чөлөөлөх саналаа чуулганы хуралдааны цагт өргөн мэдүүлсэн бол энэ асуудлыг нь ажлын 5 хоногийн дотор Их Хурал заавал энийг танилцъя. Энийг бол хугацаа зааж өгье. Тэгэхгүй бол хугацаагүй байгаад байхаар төрийн үйл ажиллагааны тасралтгүй чанар алдагдаж байна гэж үзэж энэ саналыг, хуулийн төслийг боловсруулсан байгаа гэдгийг хэлье. Ундрам гишүүн бас хууль санаачлагчийн хувьд нэмж хариулж бас болох байх.

Б.Жавхлан: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Тэгвэл одоо бүх хууль, бүх санал хураалт дээр анх гаргасан санал гэдгийг анх санаачлагч хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлж санаачилж байгаа гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч тэр саналаар явна гэж ойлголоо. Хэрвээ ингэж ойлгох юм бол нөгөө Байнгын хорооны дүгнэлт гэдэг зүйл огт хэрэггүй болох нь байна шүү дээ. Дөнгөж сая бид нар 1 зүйл хэлэлцэж байна шүү дээ. Зарим Байнгын хороо дээр тухайлах юм бол энэ хаврын чуулганаар дараалалд ороогүй хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх гээд санал хурааж байна шүү дээ манай Байнгын хороо. Тэгэхээр тэр дээр санал хураагаад, түрүүчийн 7 хоног дээр миний санал уначихсан байсан. Тэгэхээр тэр бол хамаагүй болох нь байна шүү дээ. Шууд чуулган руу орно л гэсэн үг болох нь. Тэгж ойлгож болж байна уу.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүн хариулж тодруулъя.

М.Бадамсүрэн: Энэ дээр бол нийтлэг зарчмыг зааж өгч байгаа. Жишээлбэл, би танд уншиж өгье. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Дэгийн тухай хуулийн 10.8 дээр гишүүн санал хураалтад оролцохдоо зөвшөөрсөн эсвэл татгалзсан саналын аль нэгийг өгнө гэсний дараа чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төсөл тодорхой асуудал хэлэлцэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг дэмжих эсэхээр санал хураана гэж байгаа юм. Байнгын хороо бол улам үнэ цэнтэй болно гэж би бол бодож байгаа. Яагаад гэхээр мэргэжлийн Байнгын хороо дээр дэмжсэн гэдгийг чуулганы нэгдсэн хуралдаанд заавал танилцуулна. Энэ саналыг мэргэжлийн Байнгын хороо дэмжсэн юм гэдгийг тодотгож өгнө. Дэмжээгүй

саналыг ч гэсэн дэмжих эсэхээр хураана. Гэхдээ энэ саналыг манай Байнгын хороо дэмжээгүй. Гэхдээ гишүүн өөрөө эрхийнхээ дагуу энэ саналыг хураалгая гэсэн. Жишээлбэл, намын зохион байгуулалтын хувьд бол ингэдэг шүү дээ. Намын төлөөллийн төв байгууллага дээр хэнд саналаа .../минут дуусав/

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүн ээ, гэхдээ наадах чинь ингэх юм биш үү. Та бас нэг эргэж хараарай. Анхны хувилбараар нь Их Хурал дээр шууд хэлэлцэнэ гэхчээр чинь Байнгын хорооны хэрэг ер нь байхгүй болчих юм биш үү. Үгүй ээ, яах вэ ажлын хэсэг нь тусдаа байж болно. Тэгэхдээ Байнгын хороо чинь өөрөө ямар ч үүрэггүй болчих юм биш үү. Байнгын хороогоор хэлэлцэх ямар ч шаардлагагүй болчихож байгаа юм биш үү. Лувсаннъямын Гантөмөр гишүүний микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Энэ парламент бол асуудлыг шийдэхийн тулд процессоо яаж хийсэн ч өөрийнх нь эрх шүү. Энийг манай парламентын гишүүд эхлээд бүгдээрээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй шүү. Тэгэхгүйгээр Цэц биднийг буруу гэсэн гээд дэмжсэн, дэмжээгүйг аль нэг газар ярьж болно, болохгүй гэж өнөөдөр ярьж эхэлж байгаа бол буруу. Засгийн газрыг Их Хурал чөлөөлсөн. Энэ бол дефакто. Гарсан шийдвэрийг нь энд тэнд будилуулсан. Дахиад энэ бол хуулийн сурах бичигт орох ийм зүйл болж өнгөрсөн шүү хэдүүлээ. Яаж ч шийдэж болно. Яг одоо Бадамсүрэн нарын гишүүд юу хэлж байгаа вэ гэхээр Байнгын хороо дээр хэлэлцүүлэг хийхгүй гэж байгаа юм. Болно. Санал хураалт Байнгын хороо дээр хийхгүй байж болно. Байнгын хороо дээр санал хураадаггүй парламент дэлхий дээр маш олон байгаа. Ялангуяа хөгжсөн улсууд хуулийг дур зоргоороо өөрчилдөг байдлыг алга болгож байгаа юм. Тэр ажлын хэсэг энэ тэр гэдэг юм чинь хууль өргөн барихаас өмнө байдаг юм байна лээ Японд бол.

Тэгэхээр хэдүүлээ одоо шийдэл гаргах гэж байна. Байнгын хороон дээр санал хураалтыг ямар ч санал хураадаг байсан бүх анхны өргөн барьсан асуудал босоогоороо чуулган дээр санал хураана шүү гэдэг ийм л зүйлийг Бадамсүрэн шийдэх гэж байна шүү дээ. Энийг аваад явж болно. Ингэвэл бид нар хөгжсөн орны парламент руу 1 алхаж байгаа юм. Тэгэхдээ дүлгэнэлгүйгээр чуулганы нэгдсэн хуралдаан дээр санал хураалт явна гэдэг зүйлийг нэг мөр шийдэх хэрэгтэй. Тэр байнгын хороо дээр санал хураахгүй гэдэг зүйлээ бид нар шийдчихмээр байгаа байхгүй юу. Байнгын хороо тодорхой шийдвэр гаргах эрх нь тусдаа хадгалагдаж үлдэнэ. Яг хуулийн зүйл заалт дээр бол зөвхөн чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураалтаар шийднэ. Энэ бол бид нар нэг алхам урагшаага алхчихна. Яагаад бид нар байнгын хороон дээр их олон санал хураалт явдаг вэ гэхээр Монгол өөрөө ардчиллын эрсдэлтэй улс учраас ямар нэгэн бизнесийн болоод тодорхой бүлэглэлийн эрх ашиг үйлчлүүлэхгүйн тулд Байнгын хороод дээр 2, 3 үе шаттай хэлэлцүүлэг хийж, 2, 3 үе шаттай санал гаргаж, энэ санал хураалт болгоноо эцэслэн шийддэг ийм нөхцөлийг бид нар 1992 онд авчихсан юм байна лээ. Би одоо хөгжсөн улсууд дээр очоод зөндөө асуудаг юм. Та нар болохоор чуулган дээрээ нэгдсэн хуралдаан дээрээ асуудал шийдээд байна. Бид нар Байнгын хороо дээр бөөн юм болоод байна. Ямар ялгаатай юм бэ гэхээр танай улс ардчилсан улс болохын тулд хугацаа хэрэгтэй байгаа байх. Тийм учраас их олон шаттай хэлэлцүүлэг хийдэг байх гээд байгаа юм. Тэгэхээр одоо хэдүүлээ асуудлаа шийдээд .../минут дуусав/.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүн хариулъя.

М.Бадамсүрэн: Гантөмөр гишүүнтэй санал 1 байгаа. Яагаад гэвэл эцсийн шийдвэрийг бол ард түмний төлөөлөл парламентын нэгдсэн хуралдааны чуулганаар л шийдэгдэнэ. Одоо намын тухайд ч гэсэн адилхан шүү дээ. Намын бага

хурал эцсийн шийдвэрийг л гаргадаг. Тэнд тэр намын Удирдах зөвлөл дээр энэ хүнийг дэмжээгүйг дэмжье гэдгээр санал хураадаг юм бол байхгүй шүү дээ. Тийм учраас энийг тодорхой болгож өгье. Тэгээд жоохон шинэчлэл бас бидэнд хэрэгтэй байгаа. Өмнө гарсан сургамжтай зүйлээс санаа авахад. Тэгэхээр ингээд заавал байдаг л юм байдгаараа л байх ёстой гэж бид нар бас бодож болохгүй ээ гэж үзэж энэ хуулийн төслийг 33 гишүүн санаачлан өргөн барьсан байгаа.

Байнгын хорооны үнэ цэн улам нэмэгдэнэ гэж бодож байгаа. Яагаад гэвэл Байнгын хороон дээр дэмжигдсэн гэдэг нь чуулган дээр санал хураахад нэг гол үзүүлэлт болно. Мэргэжлийн Байнгын хороо дэмжсэн, дэмжээгүй гэдгийг нь хэлнэ шүү дээ. Ийм учраас манай Байнгын хороо дэмжсэн. Ийм учраас дэмжээгүй гээд. Тэгвэл хамаагүй тэгээд дэмжээгүй саналыг дэмжье гэдэг энэ хаана ч байхгүй, дэлхийд байхгүй томъёоллоороо тэгээд яваад байвал яваад л байна. Тэгээд үр дүнгүүд чинь энэ шал өөр гардаг шүү дээ. Төсөв дээр өөр гардаг. Тэгээд яг үнэндээ чуулгын тамхийг орхиод гараад явчихсан бараг тэн хагас шахуу гишүүд нь эс үйлдэхүйгээрээ энэ саналыг чинь босгож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зөв зарчим мөн үү. Ийм улс орныг би бол сайн мэдэхгүй л байна. Тийм учраас энэ зүйлийг бол ингээд Байнгын хороо бол улам үнэ цэнтэй болно гэдгийг тодотгож хэлж байгаа. Байнгын хороо дээр харин дэмжүүлэхийн тулд хүмүүс анхаарна. Тэгэхгүй бол Байнгын хороон дээр дэмжүүлэхгүйн тулд бараг зарим нь анхаарч байна шүү дээ.

Б.Жавхлан: Гантөмөр гишүүн асуулт асууж, хариулт авлаа. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Асуудлынхаа голыг ерөөсөө олохгүй байгаа юм. Үндсэн хуулийн цэц дээр ч гэсэн бас асуудлын голоо олоогүй. Асуудлын гол нь юу байсан бэ гэхээр чуулганы ирцэд бүртгүүлчхээд тэгээд санал хураалтад оролцохгүй гараад явчихдаг гишүүдийн проблем байхгүй юу, асуудал байхгүй юу. Энийг Байнгын хорооноос дэмжээгүй саналыг дэмжье гэж саналын хэлбэрийг өөрчлөх байдлаар шийднэ гэвэл энэ бүр том эндүүрэл. Энийг шийдэх гээд юу болсон бэ гэхээр санал хураалтын ирц гэж тусдаа ирцтэй байя гэдэг хувилбарыг сонгоод сая Улсын Их Хуралд өргөн барьсан шүү дээ. Чуулганы ирц бол тусдаа, санал хураалтын ирц бас тусдаа. Одоо нөгөө парламентууд чинь санал хураалт болохоос 5 минутын өмнө парламентын байшингаар тэр чигээрээ хонх дуугараад, ямар ч ажилтай байсан бүгд сандарч гүйгээд, санал хураалт дээрээ очоод, тэгээд бүртгүүлж байгаа байхгүй юу. Тэгээд өглөөний ирц биш, санал хураалтын ирц гэж тусдаа гараад, тэгээд нөгөө улс орнууд чинь дахиад маш чухал зарчим нь парламентын гишүүн биечлэн саналаа өгнө гэдэг энэ зарчмыг бүр нарийн хуульчлаад өгчхөж байгаа байхгүй юу. Тэгээд та санал хураалтад биечлэн оролцоно. Ирцийг чинь шинээр бүртгэнэ. Тэгээд санал хураалтад биечлэн оролцсон энэ санал хураалтаар чинь хариуцлага тооцно гэдэг систем ажиллаж байгаа юм. Германд бол сүүлд 4 мянган еврогоор торгодог болчихсон байсан уу даа. Санал хураалтад оролцоогүй бол. Ийм арга замаар энийг шийдэх болохоос биш Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэж саналын хэлбэрийг өөрчлөх байдлаар шийдэгдэхгүй. Гишүүдийн хэлж байгаа бол үнэн. Энэ чинь мэргэжлийн Байнгын хороог байхгүй гэж үзэж байгаатай яг адилхан болчихно. Угаасаа тэнд санал хураахгүй, эсвэл тэндэх дуу хоолойг сонсох албагүй юм чинь гэх юм бол Байнгын хороогоор энэ хуулиудыг хэлэлцэх ямар ч утгагүй болчихно. Та бол зөвхөн Ерөнхий сайдыг огцруулах асуудал биш, бүр энэ хуулийн хэлэлцүүлэг дээр энэ саналаа оруулж ирж байна лээ шүү дээ. Тэгэхээр мэргэжлийн Байнгын хороо гэдэг чинь ямар ч үнэ цэнгүй болно.

Дэлхийд 2 төрлийн парламент байгаа. Байнгын хороон дээрээ үндсэн ажлаа нугалдаг Герман маягийн загварын парламент байна. Чуулган дээрээ үндсэн ажлаа нугалдаг арай өөр загвар. Тэр нь Англиас уламжлалтай маягийн парламент байна. Монгол Улс бол үндсэндээ Герман маягийн парламентыг сонгож авсан. Герман маягийн парламентыг сонгож авсан учраас нөгөө ажил хэрэг чинь ярьдаг биш ажил хэрэгч парламент гэж ярьдаг энэ агуулгаараа байгаа. Ажил хэрэгч парламентын чинь гол ажлыг нугалдаг нь мэргэжлийн Байнгын хороо. Мэргэжлийн Байнгын хороо дээр хэлэлцүүлэг өрнөж, санал гарч тэр мэргэжлийн Байнгын хороон дээрээсээ саналтайгаа холбогдуулж бүр үгээ хэлэх эрхээ хүртэл авах ёстой гэж үздэг тийм парламентын тогтолцоотой. Тэгээд бид хэд таны яг энэ саналаар явах юм бол одоо бол нөгөө ярьдаг буюу мэтгэлцдэг англи маягийн загварын парламент руу илүү алхана гэсэн үг. Мэргэжлийн Байнгын хороогоо сулруулна гэсэн үг байхгүй юу. Тэгээд би бол .../минут дуусав/

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүн тодруулах уу. Бараг үг хэлчихлээ. Санал хэлчихлээ.

Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Уучлаарай. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Бадамсүрэн нарын гишүүдийн санаачилсан дэгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл бол сая Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, мэргэжлийн аппарат дээрээ тулгуурлаад гишүүдийнхээ оролцоон дээр тулгуурлаад Их Хурлын 3 хуульдаа оруулсан өөрчлөлтийн дэгийн хуульд оруулж байгаа нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө агуулга бол нэг болчхож байгаа юм. Санал хураалтын өмнөх ирцийг үүсгэдэг болчихсон. Тэгээд нөгөө биеэр, эс үйлдэхүйгээр биш биеэрээ байж байгаад саналаа өгөх тухай ойлголтын асуудлыг гаргаж ирсэн. Үүгээр нэлээн олон асуудлууд цэгцэрч шийдэгдэнэ гэдгийг 1 дүгээрт хэлмээр.

2 дугаарт бас нэг кэйс бид ярьцгаагаад байгаа юм. Үндсэн хуульд тусгайлсан зохицуулалтаар орчихсон томъёоллыг бид хэд дэгийнхээ хуульд оруулаагүй байж байгаад тэр нь эргээд Үндсэн хуулийн зөрчил болж гарч ирж байгаа байхгүй юу. Тэр Засгийн газрын Ерөнхий сайдыг огцруулах үйл явц бол тэдэн гишүүн тийм асуудал гаргавал, тэд хоногийн дараа хэлэлцэж эхлээд, тэд хоног дотор багтааж хэлэлцэж дуусгана. Байнгын хороо хэлэлцэнэ. Дүгнэлтээ танилцуулна. Чуулган дээр хууль санаачлагчдын гаргасан тэр анхны томъёолол нь санал хураана гэдэг ийм утга санаа бүхий зохицуулалттай Үндсэн хуулийн заалтад нийцүүлж, дэгийн хуулиа өөрчлөөгүй байснаас холбогдоод сая ийм зөрчлийн асуудал үүсэж байгаа юм. Тэгээд үүнийгээ бол бид зөвтгөх янзгүй, хууль хоорондын нийцэл хангаагүй байна гэсэн энэ үзэл санаа гэж.

3 дахь санаа бол бид яах аргагүй энэ мэргэжлийн Байнгын хороо дээрээ ажлаа нугалдаг ийм парламент. Тийм учраас энэ зарчмаа барих ёстой. Үндсэн хууль юманд тусгайлсан томъёоллоор л зохицуулагдчихаагүй бол ерөнхийдөө тэр санаагаа барьдаг, Байнгын хорооныхоо дүгнэлтийг барьдаг энэ зарчмаараа явах нь зөв. Тийм учраас би энэ хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг нь дэмжээд, төсөл өргөн баригч өөрөө зөвшөөрвөл өмнө хэлэлцэхийг нь дэмжчихсэн байгаа Дэгийн тухай хуультайгаа хамтатгаж, хэлэлцээд явах нь зөв байх. Тэнд ажлын хэсэг гарна. Тэр ажлын хэсэг дээр тал бүрээс нь яриад, энэ

давхцал юмнуудыг нь арилгаад ингээд явчих бололцоо байгаа гэж би энэ талаас нь хараад дэмжчих нь зөв юм уу гэж ингэж бодож байна.

Б.Жавхлан: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад илтгэе. Алтангэрэл, Ариунзаяа, Батбаатар, Бат-Эрдэнэ, Баярбаатар, Баярмаа, Болормаа, Бямбацогт, Гантөмөр, Мөнхбаатар, Номтойбаяр, Пүрэвдорж, Хэрлэн, Энхбаяр, Энхтуяа гишүүд ирцэд бэлтгэж, төхөөрөмжөө идэвхжүүлнэ үү. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хурааа. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 4 гишүүн зөвшөөрч, 21,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хурааа. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 4 гишүүн зөвшөөрч, 21,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Саналаараа танилцуулах гишүүн байна уу. Ганбаатар гишүүн танилцуулна.

16.01 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин 2025 оны 12 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх зарчим нь засгийн бүх эрх ард түмнээс эх сурвалжтайг илэрхийлэх бөгөөд иргэд өөрсдийн дундаас сонгогдож эрх мэдлийг шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгчөөр уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцдог.

Дээрх агуулгаар ард түмнээс эрх мэдлийг шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгч нь ард түмний хүсэл зоригийн илэрхийллийг дамжуулагчийн хувьд түүнд тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлж, өөрийн болон төрийн үйл ажиллагааг ард түмний хяналтад байлгах бүхий л бололцоог хуулиар нээж өгөх үүргийг энэхүү зарчмын хүрээнд хүлээдэг.

Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1-д Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэг, түүний үр дүн, төлөөллийн бүрэн эрхийг хэрэгжүүлж буй гишүүний саналыг иргэдэд ил тод нээлттэй мэдээлж байх нь төрийн үүрэг мөн. Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх харилцааг хэт ерөнхий хуульчилсан байдаг.

Уг зохицуулалтууд нь хэлэлцүүлгээс гарсан шийдвэр, санал хураалтын үр дүнг нийт иргэдэд мэдээлэх бус нэвтрүүлэх, албан хэрэг хөтлөх, тэмдэглэлийг хадгалах шинжтэй байна. Тодруулбал, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 1-д чуулганы хуралдааныг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх, түүнчлэн телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулна гэж заасан ганцхан зохицуулалтаар л мэдээлэх ажлыг зохицуулж байна. Энэ зүйлийн хэрэгжилт нь чуулганы хуралдааныг телевизийн суваг, парламентын албан ёсны, цахим хуудсаар шууд дамжуулах хэлбэрээр хэрэгждэг.

Харин иргэдийн гол анхаардаг асуудал нь аливаа хууль тогтоолын төсөл батлагдсан эсэх буюу санал хураалтын үр дүн өөрийн сонгосон гишүүн болон бусад гишүүдийн өгсөн саналтай танилцах байдаг. Телевизээр шууд дамжуулах хэлбэр нь иргэдийн дээрх мэдэх эрхийг хангаж чаддаггүй, шууд дамжуулалтыг бүтэн үздэг хүн ховор. Үзсэн ч санал хураалтын дүнг танилцуулж буй дэлгэц нь бүрэн бус гараад өнгөрдөг учраас санал хураалтын үр дүнтэй танилцах боломжгүй байдаг.

Улсын Их Хурлын гишүүд ч санал хураалтын дэлгэцийн зургийг авах байдлаар хуульд заасан санал хураалтын дүнтэй хязгаарлалтгүйгээр танилцах эрхээ хэрэгжүүлж байна.

2024 онд байгуулагдсан парламентын үйл ажиллагааны хугацааны чуулганы хуралдааны санал хураалттай холбоотой хэд хэдэн асуудал үүссэн бөгөөд тухайн цаг үедээ шийдвэрлэгдээгүй өнгөрсөн. Учир нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журмыг хуульчилсан.

Тус зүйлийн 135.3.3-д санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг, 135.3.4-д тухайн хурлын ирцийг хурлын тэмдэглэлд тусгахаар заасан.

Харин тэмдэглэл хөтлөх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга 2024 оны 624 дүгээр захирамжаар баталсан журмаар зохицуулж байгаа бөгөөд тэмдэглэл бэлэн болоход урт хугацаа шаарддаг. Тодруулбал, тус журмын 2.1-д “шинжээч хуралдааны товч тэмдэглэлийг тухайн хуралдаан дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор бэлэн болгоно.” гэж, 4.2-т “референт бэлэн болсон хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 3 өдрийн дотор хянана.” Гэж, 4.3-д “нэгжийн дарга энэ журмын 4.2-т заасны дагуу хянагдсан чуулганы нэгдсэн хуралдааны товч

тэмдэглэлийг ажлын 2 өдрийн дотор хянана.” Гэж, 4.8-д “шинжээч энэ журмын 4.7-д заасны дагуу хянагдсан нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар албажуулахаар Ерөнхий нарийн бичгийн даргын туслахад ажлын 2 өдрийн дотор хүлээлгэн өгнө.” гэж тус тус заасан бөгөөд санал хураалтын дүнг агуулсан чуулганы хуралдааны товч тэмдэглэл боловсруулахад ажлын 12 хоног зарцуулахаар байна.

Мөн тус журмын 3.3-т “шинжээч яриаг бичвэрт буулгах системийн тусламжтайгаар дууны бичлэгийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл буулгах ба ажлын 5 өдрийн дотор эцэслэн хянаж бэлэн болгоно.” гэж, 6.1-д “шинжээч нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл албажсан даруйд дэлгэрэнгүй тэмдэглэлийн хамт ажлын нэг өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудас байршуулна.” гэж тус тус заажээ.

Дээрх журамд заасан цаг хугацаануудыг нэгтгэхэд чуулганы хуралдааны саналын дүн нийт ажлын 13 өдрийн дараа буюу санал хурааснаас хойш 3 дахь 7 хоногийн сүүлээр Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршихаар байна. Дээр дурдсан чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх хуулийн зохицуулалт, арга хэрэгсэл нь Улсын Их Хурлын тухай хуулийн 3.4-д Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлээ хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод байх гэж, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3.1-д Улсын Их Хурлын чуулганы хуралдаан хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх зарчимд үндэслэнэ гэж заасанд нийцэхгүй байна.

Иймд чуулганы хуралдааны чухал ач холбогдолтой хэсэг буюу хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүн, гишүүн бүрийн саналыг тухайн өдрөө товч мэдээлэл хэлбэрээр Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулан санал хураалтын ил тод нээлттэй байдлыг хангах шаардлагатай байна.

Энэхүү хуулийн төслөөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд заасан чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх журмыг боловсронгуй болгож, чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийг явуулсан хуралдааны санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд товч хэлбэрээр тухайн өдрөө байршуулахаар тусгана.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1-д Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж, 27 дугаар зүйлийн 7-д Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж, асуудлыг шийдвэрлэнэ гэж зааснаар Улсын Их Хурлын нээлттэй, ил тод байдал сайжрах, сонгогчдод ил санал хураалтаар шийдвэрлэсэн асуудлын үр дүнг богино хугацаанд авах өөрийн сонгосон гишүүний байр суурь, өгсөн саналыг мэдэх эрхийг баталгаажуулах, ард түмний засаглах эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэхээс гадна иргэдийн төрд итгэх итгэлд эергээр нөлөөлнө.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Хэлэлцэж өгнө үү. Баярлалаа.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Асуулт алга байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн дэмжээгүй байр суурь илэрхийлэх, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт бэлэн боллоо. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 31,6 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 5 гишүүн зөвшөөрч, 26,3 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн саналаараа танилцуулах гишүүд байна уу. Ариунзаяа гишүүн 2 болчихлоо. Хэрлэн гишүүн танилцуулна.

16.11 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал нарын 4 гишүүн 2026 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүнд микрофон өгье. Горимын санал юм уу.

Х.Баасанжаргал: Одоо энэ хуулийн төслийг хэлэлцлээ гэхэд ирц яг энэ байгаа танхимын бүрэлдэхүүнийг харах юм бол санал дэмжигдэхээргүй, яг ирцийн хувьд бол хангалттай биш л байна л даа. Яг ирцэд орсон хэр нь гишүүд өөрсдөө хуралдаанд суугаагүй байна. Тэгэхээр яг энэ ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг

хэрвээ бид нар унагах юм бол энэ чинь өөрөө нийгэмд гишүүд өөрсдийнхөө ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг зохицуулахаас татгалзаж байна, зайлсхийж байна гэдэг асуудал харагдана шүү дээ. Тэгэхээр яг энэ асуудал дээр ямар байдлаар хойшлуулах ёстой вэ. Эсвэл гишүүдээ хүлээх үү. Ямар байдлаар санал хураалтыг явуулах вэ гэдэг дээр. Горимын санал гэсэн үг.

Б.Жавхлан: Дэгийн тухай хуулийн 13.3-д “хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч түүний хэлэлцүүлгийг горимын саналаар хойшлуулсан тохиолдолд хуралдаан даргалагч дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ.” гэж байгаа. Дэгийн тухай хуулиар горимын санал гаргасан бол заавал санал хураана. Тэгэхээр Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүний гаргасан горимын саналаар хууль санаачлагчийн танилцуулсан асуудлыг өнөөдрийн хуралдаанд хэлэлцэх асуудал батлагдсан жагсаалтаас хасаж хойшлуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Гишүүний гаргасан горимын санал дээр 19 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 36,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна.

Х.Баасанжаргал: Харамсалтай байна. Тэгэхдээ ямар ч байсан танилцуулгаа уншъя. Тэгээд чуулган дээр гишүүдийг бас энэ саналыг босгож өгөх байх гэж хүсэж байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал 126 гишүүнтэй болсноор нийгмийн олон талт төлөөлөл бүхий парламент бүрдэх нөхцөл бий болсон. Ингэснээр ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагад сонгогдон ажиллаж буй гишүүдийн хувьд өргөсөн тангарагтаа үнэнч байж бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлага тэр хэрээр нэмэгдсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-т гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахыг хориглосон бол Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4.1-д гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, улс төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баримталж ажиллана гэжээ.

Түүнчлэн Нийтийн албанд болон нийтийн хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөрт нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна. Мөн зүйлийн 6.4-д албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болохуйц нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт 2.4-д төрийн өндөр албан тушаалтан түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно гэсэн болно. Мөн Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 5.3-д оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж тэмцэхэд нийцэхүйц байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох эрх зүйн

баримт бичиг болон захиргааны арга хэмжээнд тогтмол дүгнэлт хийж байхыг чармайна гэсэн болно.

Монгол Улсын хувьд авлигын төсөөллийн индексээр сүүлийн 9 жилийн хугацаанд тогтмол оноо буурч, 2024 оны байдлаар 180 орноос 114-д эрэмбэлэгдэж байсан бол 2025 оны байдлаар 124-д эрэмбэлэгдэж байгаа бөгөөд нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглах авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үзүүлэлтээр хангалтгүй үнэлэгдсэн хэвээрээ байна. Парламент нийгмийн хөгжлийн үндсэн асуудлыг ардчилсан зарчмаар шуурхай шийдвэрлэхийн тулд үйл ажиллагааныхаа үр өгөөжийг дээшлүүлэх, тухай бүр боловсронгуй болгож байх ёстой институц. Төрийн эрх барих дээд байгууллагын хувьд бусад байгууллагын хувьд үлгэр жишээ байх учиртай.

Ийм учраас Улсын Их Хурлын гишүүн миний бие Ганмаа, Лувсанжамц, Эрдэнэбат нарын хамт санаачлан энэхүү хуулийн төслийг танилцуулж байна.

Дэлхийн улс орны парламентын үйл ажиллагааны ил тод, шилэн байдлаа хангахын тулд өөрийн гишүүдийн ашиг сонирхлын мэдүүлэг бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн. Тухайлбал, Их Британи улсын парламентад ашиг сонирхлын бүртгэлд тогтмол хөтөлдөг бөгөөд тухайн чуулганаар хэлэлцэж буй асуудлын талаар гишүүдийн хийсэн мэдэгдэл тухайн гишүүдийн цалин хөлс, шагнал урамшуулал, гадаад, дотоод томилолтод зарцуулсан зардал зэргийн талаар тогтмол мэдээлж хэвшжээ. Европ парламент өөрийн гишүүдийн санхүүгийн ашиг сонирхлын бүртгэлийг тогтмол хөтөлдөг бөгөөд уг бүртгэл парламентын албан ёсны веб хуудаст нээлттэй байршдаг.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7.2-т хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ гэсэн ба Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуулийн 25.1-д албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна гэж тус тус заасан. Иймд Улсын Их Хурлын гишүүдийн хувийн ашиг сонирхлын болон ХОМ мөн тухайн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээд орлого олж байгаа эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй тухай гишүүний мэдэгдлийг Улсын Их Хурал албан ёсны цахим хуудастай нэгэн адил нийтэлж, иргэдийн мэдэх эрх, парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана гэж үзлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар гишүүн тодорхой асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй бол хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг хориглосон. Энэхүү хязгаарлалтыг хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мөн адил хамаарахаар зохицуулах нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.23-д заасан үүргийг бодитой хэрэгжүүлэх механизм бүрдэнэ гэж үзлээ.

Дэлхийн ихэнх улсын парламентад хэлэлцэж буй асуудлын талаар ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд санал хураалтад оролцохгүй байх замаар тухайн асуудлаарх байр сууриа илэрхийлдэг жишиг түгээмэл байна. Энэхүү жишиг нь зөвхөн тухайн гишүүн өөрөө болон түүний гэр бүлийн гишүүдээр хязгаарлагдахгүйгээр эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, нэгдмэл сонирхолтой этгээдийг ч мөн хамаардаг. Гэвч өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийн хэрэгжилт хангалтгүйн улмаас

гишүүд ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед санал хураалтад оролцохгүй байх үүргээ санаатай болон санамсаргүй шалтгаанаар тухай бүр биелүүлж чадахгүй ирсэн байдаг. Энэ тухай лавлагаа авч үзэхэд ийм тохиолдол ердөө хоёрхон удаа тохиолдож байсан байна.

Хэлэлцэж буй асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, санал хураалтад оролцоогүй гишүүн хуралдааны ирцтэй байх нь түүний бүрэн эрхийн асуудал ч ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, санал хураалтад оролцоогүй бөгөөд ирцээсээ гараагүй байгаа гишүүнийг эсрэг санал өгсөнд тооцсон тохиолдол мөн гарч байлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10-ын дугаар зүйлийн 10.11 дэх хэсэг тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан эсвэл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж, тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэсний дагуу бүртгэлээс гарсан ч эсрэг санал өгснөөр тооцох эрсдэлтэй байна.

Мөн түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 8 дугаар дүгнэлтэд Улсын ИХ Хурлаас аливаа шийдвэр гаргахад зөвхөн санал өгсөн гишүүний тоог тоолох нь Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх зарчимд илүү нийцнэ гэжээ. Ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, санал хураалтад оролцоогүй гишүүнийг ирцэд нь оруулан тооцох зохицуулалт хэрэгжсэнээр Улсын Их Хурлын гишүүн санал өгөх бүрэн эрхээ хөндлөнгийн нөлөөлөлгүй хараат бусаар эдлэх боломж бүрдэж, чуулганы хуралдааны ирц нэмэгдэх эерэг үр дагавар гарна гэж үзлээ.

Хуулийн төсөл батлагдсанаар парламентын ардчилсан ил тод байдлыг хангах, гишүүдийг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа илүү боловсронгуй, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой, тодорхой болох эерэг үр дүн гарч, хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын гишүүдийн ирц, идэвх оролцоо, сахилга хариуцлага нэмэгдэж, ард түмний засаглах эрхийг бодитой хангахад эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Төрийн байгууллын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Жавхлан: Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Болормаа гишүүнээр тасаллаа. Болормаа гишүүний микрофоныг нээе.

Э.Болормаа: Баасанжаргал нарын гишүүдийн өргөн барьж байгаа энэ хуулийг бол дэмжиж байгаа. Тэгээд би 1 зүйлийг зүгээр тодруулж асуух гэсэн юм. Хэрвээ аливаа гишүүн ашиг сонирхлын зөрчилтэй асуудал дээрээ санал хураалтад гэхээр

та яг тодорхой хэлээд өгөөч. Өөрийгөө түдгэлзсэнд оруулах юм уу эсвэл ирцээс гарахаар болж байна уу.

Б.Жавхлан: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Энд 1 ийм ялгаатай юм байдаг юм байна лээ. Эхлээд яах вэ түдгэлзсэн гэдгээр орохоор түдгэлзсэн гэдэг нь улс төрийн идэвхтэй шийдвэр гаргалтын 1 төрөлд ордог юм байна. Гэтэл ашиг сонирхлын зөрчил гэдэг нь үүрэг юм байна. Энэ ерөөсөө улс төрийн шийдвэр биш. Таны ёс суртахууны үүрэг учраас энэ дээр ямарваа нэгэн байдлаар түдгэлзэх гэдэг санал хураалтад орох ёсгүй байдаг юм байна. Би бас нөгөө түдгэлзэх санал хураадаг парламентын жишгүүдийг судалсан. Тэгэхээр яг энэ нөгөө түдгэлзэх гэдэг 3 дахь төрлийн саналын 1 сонголт гэсэн үг шүү дээ. Тэгэхээр ийм сонголт руу бол энэ ёс зүйн асуудал бол орох ёсгүй. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй гэдгээр явах ёстой байдаг юм байна. Тэгэхээр түдгэлзсэн гэдэг санал руу орж болохгүй.

2 дугаарт гэвэл ирцтэй байгаа хэр нь ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ урьдчилж хуралдаан даргалагчид мэдэгдээд, санал хураалтын дэлгэц дээр зөвшөөрсөн татгалзсан нөгөө санал хураалтын төхөөрөмжөө идэвхгүй болгосон буюу ашиг сонирхлын зөрчилтэй улмаас санал хураалтад оролцоогүй гэдэг ийм 3 урдах байдлаар орж ирж байгаа гэсэн үг.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл төслийн үзэл баримтлалтай ... Уучлаарай. Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Тэгэхээр хэрвээ юу гэдэг юм. Барилгын бизнестэй гишүүн барилгын асуудал дээр тусгай сангаас юм уу дэмжлэг авах ийм асуудал гарч ирвэл өөрөө түүнийгээ мэдүүлээд, тэгээд энэ дээр нь түдгэлзэх бус ашиг сонирхлын зөрчилтэй учир гэдэг ийм шинэ товчлуур нэмж орж ирнэ гэж ойлгож болох уу. Энийгээ яагаад түдгэлзэх гэдгээр нь оруулж ирэхгүй. Сая та энийг тайлбарлаад байна л даа. Хоёулаа бас энийг өмнө нь ярилцаж байсан учир би тэгээд энийг түдгэлзэх гэдгээр нь орж ирвэл зүйтэй юм болов уу гэж бодоод байна. Тэгэхгүй бол одоо бид нар зөвшөөрсөн, татгалзсан гэххээд 3 дахь товчлуур нь ашиг сонирхлын зөрчилтэй учир санал хураалтад ороогүй гэж зохицуулах болж байна уу л гэдгийг тодруулъя.

Б.Жавхлан: Баасанжаргал гишүүний микрофоныг нээе.

Х.Баасанжаргал: Төрийн өндөр албан тушаалтнуудын ашиг сонирхлын асуудлыг ер нь дэлхийн бусад улс орны парламент 3 үе шаттай шийддэг юм байна.

1 дүгээрт тухайн асуудлыг хэлэлцэхээс өмнө урьдчилж заавал мэдэгдэх гэдэг процесс заавал байх ёстой юм байна. Энэ процесс манай дээр байгаа хэр нь хэрхэн, яаж, хэзээ, хэнд гэдэг нь огт байхгүй байгаа юм. Энийг 1 дүгээрт тодорхой болгож байгаа гэсэн үг. Ингээд урьдчилаад мэдэгдэхээр яах вэ гэвэл гишүүн ирцдээ орсон хэр нь ямар нэгэн нэмэлт кноп ерөөсөө дарахгүй, ирцдээ орчихно. Төхөөрөмж нь идэвхгүй болно. Санал хураалт нь идэвхгүй болно. Гэхдээ дэлгэц дээр заавал ашиг сонирхлын зөрчилтэй гээд санал өгөөгүй 1 гишүүн гэдэг нь заавал хуралдааны тэмдэглэлд, мөн дэлгэц дээр нээлттэй ил тод харагдах ёстой юм байна лээ. Манай дээр бас энэ процесс ерөөсөө байхгүй. Би жишээ нь 2020 оноос хойш энэ Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуультай холбоотой заалт орсон хэр нь хоёрхон

тохиолдолд гишүүн ашиг сонирхлын зөрчлөө илэрхийлээд, санал хураалтад ороогүй байдаг юм байна лээ. Тэгээд энийг шүүлгэж гаргахын тулд .../минут дуусав/

Б.Жавхлан: Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Хэрвээ Улсын Их Хурлын гишүүн ашиг сонирхлын зөрчлөө заавал түрүүлж мэдэгдэх ёстой байтал мэдэгдээгүй бол ямар арга хэмжээгээр зохицуулагдах вэ.

Б.Жавхлан: Баасанжаргал гишүүн хариулъя. Микрофоныг нээе.

Х.Баасанжаргал: Одоогийн байдлаар манай Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм дээр ашиг сонирхлын зөрчилтэй бол сайн дураараа татгалзах гэдэг үг байгаа юм. Энийг энэ хуулийн төсөл дээр бас заавал татгалзах гэдэг үүрэгтэй 1 дүгээрт олгож байгаа.

2 дугаарт манай Ёс зүйн дэд хороо энэ дээр заавал ажиллах үүрэгтэй болж эхэлнэ гэсэн үг. Бас бусад улс орны туршлага нь юу байдаг вэ гэвэл Их Хурлын дарга нь энэ тохиолдолд ажлын хэсэг байгуулаад, тухайн гишүүн ашиг сонирхлын зөрчлийн улмаас санал хураалтад орчихсон гэдэг нь илэрхий болох юм бол Их Хурлын даргын санаачилгаар ажлын хэсэг байгуулж ажилладаг ийм туршлагууд байдаг юм байна лээ. Мөн зарим тохиолдолд зарим парламент бол дэргэдээ яг энэ асуудлыг хариуцсан ... заавал ерөөсөө энэ бол үндсэндээ тангаргаа зөрчсөн асуудал гэсэн үг шүү дээ. Яг үнэн. Тэгэх юм бол хэрвээ бүр тангараг зөрчсөн ноцтой түвшинд очих юм бол одоогийн процесс бол Үндсэн хуулийн цэцийн асуудал руу ч орох магадлалтай гэсэн үг.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа мөн илэрхийлж дууслаа. Та сая санал өгөөгүй байсан. Одоо өнгөрсөн. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтад 19 гишүүн оролцож 7 гишүүн дэмжиж, 36,8 хувиар санал дэмжигдсэнгүй. Жудагийн Баярмаа гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүд дэмжсэн байна. Горимын санал байвал дахиж санал хураана. Байхгүй бол санал ингээд дууслаа. Уучлаарай гишүүн горимын санал гаргасан учраас бид сонсох ёстой. Хэрлэн гишүүний микрофоныг өгье.

Б.Хэрлэн: Төхөөрөмж саатсан учраас санал хураалтыг дахин явуулж өгнө үү.

Б.Жавхлан: Хэрлэн гишүүний горимын саналаар санал хураая. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 42,1 хувиар горимын санал дэмжигдсэнгүй. Ингэхээр эхний санал хураалт хүчинтэй хэвээр үлдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хурааа. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч 42,1 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

3.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хурааа. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 36,8 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн саналаараа танилцуулах гишүүд байна уу. Жудагийн Баярмаа гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалдаа орьё.

Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2026 оны 4 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Дөнгөж сая хууль санаачлагч Жуковын Алдаржавхлан гишүүн өргөн барьсан хуулийг хойшлуулж өгөөч ээ, хүндэтгэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй байна гэж хэлсний дагуу Дэгийн тухай хуулийн 31.5-ыг үндэслэн хуралдаан даргалагчийн зүгээс хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулж байна.

16.29 цаг.

Уучлаарай та бол горимын санал гаргасан. Энэ хардаа. Энэ чинь ингэж байна шүү. Энэ хуулийн 31.5 дугаар заалт сонсчхоорой. 31.4 гишүүний санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг гишүүн өөрөө, хэд хэдэн гишүүн хамтран санаачилсан бол тэдгээрийг төлөөлөх гишүүн хийнэ гэж байна. 31.5 нь энэ хуулийн 31.1, 31.2, 31.4-д заасан этгээд төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатад оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна гэж байна.

Та өөрөө хуралдаанд оролцоод, өөрөө горимын санал гаргасан учраас тэр дэгийнхээ дагуу явсан.

Дараагийн асуудалдаа орно.

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 2026 оны 5 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Цогтбаатар гишүүний микрофоныг нээе.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал нь улсын төсөв, түүний гүйцэтгэлийг батлах, хуулийн биелэлтэд хяналт тавих онцгой бүрэн эрхтэй байхаар заасан. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлээр нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэх журмыг зохицуулж байгаа.

Гэвч өнөөдрийн мөрдөж байгаа зохицуулалтаар төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үеийн асуулт, хариултын хугацаа ердийн хуулийн төслийн хэлэлцүүлгийн нийтлэг хугацаагаар явагдаж байгаа нь төсвийн зарцуулалт, үр ашиг, аудитын дүгнэлт, сахилга хариуцлагын асуудлыг гүнзгий хэлэлцэх дутагдалтай байна.

Иймээс энэхүү хуулийн төслөөр төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед гишүүний асуулт асуух болон хариулт авах хугацааг нэмэгдүүлж, тусгайлан зохицуулахаар тусгасан. Тухайлбал, Байнгын хороо болон нам, эвслийн бүлгийн гишүүний асуулт асуух хугацааг 10 минут, асуултад хариулах хугацааг 6 минут болгож, нэмэлт тодруулга хийх боломжийг өргөжүүлж байгаа.

Мөн нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн үед ч асуулт асуух, хариултын хугацааг нэмэгдүүлж, төсвийн гүйцэтгэлийг илүү дэлгэрэнгүй, бодитой хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлд илүү үр нөлөөтэй хяналт тавих төсвийн ерөнхийлөн захирагч нараас тодорхой хариуцлагатай тайлбар авах, аудитын дүгнэлтийн хэрэгжилтэд бодитой анхаарал хандуулах боломж нэмэгдэнэ гэж үзэж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийн талаарх хэлэлцүүлгийг явуулж, хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Асуулт алга байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу. Болормаа гишүүн. Даваагийн Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Болормаа гишүүний микрофоныг нээе.

Э.Болормаа: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Бид нар ер нь бол төсвийг захиран зарцуулах, төлөвлөлт дээрээ бол маш өргөн дэлгэр хэлэлцүүлэг явагдаад, тэгээд дараа нь зарлага дээр нь хяналт тавих дээрээ төдийлөн бас хэлэлцүүлэг өрнүүлж чаддаггүй нь өөрөө бас Дэгийн хуульдаа энэ цагийн хязгаар байгаа. Тэгэхээр энэ цагийг нь нэмж өгөөд, яг бас чухал асуудал дээрээ хангалттай цагтай буюу энэ нэмэлт, өөрчлөлт дээр орж ирж байгаагаар нь нийтдээ 15 минут нэмэлт асуултаа оруулаад хэлэлцье гэж байгаа юм.

Саяхан жишээлбэл би чуулганы танхимд ч гэсэн хэлж байсан. Бид нар нийт 5,8 их наядын тендерийн худалдан авалтын 70 хувийг нь 10 компани авсан байна гээд.

Бид нар энэ жил жишээлбэл энэ эхний улирлын төсвийн гүйцэтгэлээр инфляц ийм байгаа нь төсвийн алдагдал юутай бас холбоотой вэ гэсэн төсвийн хөрөнгө оруулалт бол нэмэгдсэн, түүний гүйцэтгэл нь асар ихээр нэмэгдсэн байж байгаа. Энэ урсгал зардалтай холбоотой биш байгаа байхгүй юу. Яг статистиктай холбоотойгоор харахад. Тэгэхээр энэ яг чухал асуудал дээр хангалттай цаг гарган хэлэлцэх нь бол зүйтэй гэж үзэж, энэ хуулийн төслийг дэмжиж байна.

Б.Жавхлан: Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Яагаад энэ хуулийг санаачилсан бэ гэхээр төсвийн гүйцэтгэлийг, төсвийг батлахдаа ер нь бол Улсын Их Хурал яг хамгийн сүүлийн 2026 оны улсын төсвийг батлахдаа 9 сарын 15-нд чуулганы хуралдаан нээгээд, 11 сарын 15 болтол ер нь бол 3 сар зөвхөн төсөв хэлэлцэж батлаад 34 их наяд төгрөгийн төсвийг Засгийн газарт олгож байгаа гэсэн үг. 5 үе шатаар хэлэлцэн төсвийнхөө гүйцэтгэлийг батлахдаа буюу бид нар өнгөрсөн хугацаанд ямар ямар ажил хийж гүйцэтгэсэн бэ гэдгийг ярихдаа чуулганы хуралдаанд 3 минут, байнгын хороод дээр 3 минут ингээд үндсэндээ 6 минут асуулт асуух, нэмэлт тодруулга хийнэ гэвэл 1 минут гээд ингээд үндсэндээ 4 минутаар асуудлаа хязгаарлуулаад байгаа юм. Гэтэл нөгөө Улсын Их Хурлын сонгуулийн томсгосон тойргоор буюу жишээлэхэд Байнгын хорооны дарга Жавхлан гишүүн бол Дарханд хийсэн 1 ажлаа асуумаар байдаг. Төв аймгийн асуудлаа яримаар байдаг гэхээр цаг хугацааныхаа хувьд хүрэхгүй болоод байгаа юм. Энэ асуудлуудыг нь илүү дэлгэрэнгүйгээр улс өөрөө 34 их наяд төгрөгийг юунд үрэв. Тэр дээрээ зарцуулалт дээрээ бид нар ямар хяналттай яаж ажиллав, ажил нь яаж биелэв гэдгээ илүү тодорхой ярихын тулд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргын хувиар энэ хуулийг санаачилсан юм.

Тэгээд уг нь бол Улсын Их Хурлын дарга ч гэсэндээ сүүлийн үед хуралдаа маш их идэвхтэй суух ёстой, бүгдээрээ хуралдаа оролцоотой байх ёстой гэж ярьдаг хэдий боловч өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр ирцээ бүртгүүлчхээд өөрөө гараад явчих юм. Энэ ямар үлгэр дуурайлал болох вэ. Тэгээд энэ дээр чинь яг ингээд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх Баасанжаргал гишүүний асуудал унаж байна. Энэ Энхтүвшин гишүүний асуудал цаг хугацаа дээр дэмжсэн, дэмжээгүй асуудлаа ил тод гаргадаг больё гэдэг асуудал нь бас унаж байна гэх мэтчилнээр хэрэгтэй хуулиудаа унагаагаад байна. Зарим улс төр хийх бусад хуулиуд байж болно. Гэтэл энэ дэгийн тухай хуультай холбоотой иймэрхүү зохицуулалтынхаа асуудлуудыг уг нь цаг хугацаанд нь хэлэлцээд явчих юм бол энэ хуулийн жишээлэхэд онцлог нь бол 6 сарын 15 гээд аудитын байгууллагаас 2025 оны төсвийн гүйцэтгэл орж ирэхэд бид нар хангалттай хугацаанд ярилцъя л гэдэг ийм л хуулийн төсөл юм байгаа юм.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд та бүхнийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

Б.Жавхлан: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэлж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлж дууссан. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь

зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж 47,4 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Энэ төхөөрөмж дутуу ажиллаад байна. Горимын санал гаргая.

Б.Жавхлан: Жудагийн Баярмаа гишүүний горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 10 гишүүн зөвшөөрч, санал хураалт хүчингүй боллоо.

Дахин санал хураалт. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 52,6 хувиар уг санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүддээ талархал илэрхийлье.

16.39 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ